

**МОНГОЛ УЛС ДАХЬ
МАНСУУРУУЛАХ БОДИС,
СЭТГЭЦЭД НӨЛӨӨЛӨХ
ЭМ, БЭЛДМЭЛ, БОДИСТОЙ
ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРЭГТ
НОГДУУЛЖ БУЙ ЯЛ ШИЙТГЭЛ,
ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ**

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Улаанбаатар хот
2013 он

Судалгааны зорилго нь мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэргийн бүрэлдэхүүн, гэм буруутай этгээдэд оногдуулах ял шийтгэлийн өнөөгийн бодит нөхцөл, байдлыг шүүхийн практикт тулгуурлан, олон улсын хүний эрхийн гэрээ, конвенц, барим бичигтэй харьцуулан судалж, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр холбогдох байгууллагуудад санал зөвлөмж хүргүүлэх, эрүүгийн хууль тогтоомжид тусгуулах явдал болно.

Судалгааг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Нийслэлийн шүүх, Хүний аюулгүй байдлын судалгааны төв ТББ, бусад судлаачид хамтран гүйцэтгэв.

Судалгааны ажлыг санхүүжүүлж, хэвлүүлсэн НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хамт олонд талархсанаа илэрхийлье.

Судалгааны багийн гишүүд:

П.Оюунчимэг

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн
Хууль зүйн ухааны доктор /Ph.D/

Б.Сарантуяа

Нийслэлийн шүүхийн ерөнхий шүүгч

Б.Батцэрэн

Улсын дээд шүүхийн шүүгч

Б.Батзаяа

Хүний аюулгүй байдлын судалгааны төвийн менежер, судлаач

Г.Агар-Эрдэнэ

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын хэлтсийн дарга
Хууль зүйн магистр /LL.M/

Б.Батаа

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын хэлтсийн дарга
Хууль зүйн магистр /LL.M/

Ж.Мөнхболд


Хууль сахиулахын их сургуулийн магистр, докторын сургалтын албаны дарга
Хууль зүйн ухааны доктор /Ph.D/

З.Эрдэм

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын референт

Э.Туул

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын судлаач
Олон улсын харилцааны магистр



АГУУЛГА

НЭГ. ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

1.1 Мансууруулах бодис	5
1.2 Сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис	15
1.3 НҮБ-аас мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой асуудлаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	16

ХОЁР. ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, КОНВЕНЦООР ЗОХИЦУУЛСАН НЬ

2.1 НҮБ-ын 1961 оны Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц	19
2.2 НҮБ-ын 1971 оны Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц	21
2.3 НҮБ-ын 1988 оны Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц	22

ГУРАВ. БУСАД УЛС ОРНУУДЫН ТУРШЛАГА

3.1 Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын эрх зүйн зохицуулалтын товч түүх	23
3.1.1 1800-1959 оны эрх зүйн зохицуулалт	
3.1.2 1960-1996 оны эрх зүйн зохицуулалт	
3.1.3 1997-2006 оны эрх зүйн зохицуулалт	
3.2 Хэрэглэгч, жижиглэн худалдаалагч нарт захиргааны хариуцлага тооцож зөвхөн зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэж буй орнууд	26
3.2.1 АНУ-ын мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын эрх зүйн орчин, ялын бодлого	

3.3 Либерал шинжтэй бодлого явуулдаг орнууд 30

- 3.3.1 ХБНГУ-ын эрх зүйн орчин, ялын бодлого
- 3.3.2 Голландын эрх зүйн орчин, ялын бодлого
- 3.3.3 Португалийн эрх зүйн орчин, ялын бодлого
- 3.3.4 ОХУ-ын эрх зүйн орчин, ялын бодлого

3.4 Ялын хатуу бодлоготой орнууд 36

- 3.4.1 БНХАУ-ын эрх зүйн орчин, ялын бодлого
- 3.4.2 Зүүн өмнөд Азийн бусад орнуудын ялын бодлого

**ДӨРӨВ. МОНГОЛ УЛСАД МАНСУУРУУЛАХ БОДИС
БОЛОН СЭТГЭЦЭД НӨЛӨӨЛӨХ ЭМ, БЭЛДМЭЛ,
БОДИСТОЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРГИЙГ ХЯНАН
ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ШҮҮХИЙН БОЛОН ХУУЛЬ
ХЭРЭГЛЭЭНИЙ ПРАКТИК**

4.1 Монгол Улсын мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой эрх зүйн зохицуулалт, ялын бодлого 41

4.2 1986 оноос хойшхи шүүхийн тогтоол, шийдвэрт хийсэн судалгаа 45

- 4.2.1 1986 оны Эрүүгийн хуулиар хянан шийдвэрлэсэн мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөт эм, бэлдмэл, бодистой холбоотой хэргийн судалгаа
- 4.2.2 2002 оны Эрүүгийн хуулиар хянан шийдвэрлэсэн мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөт эм, бэлдмэл, бодистой холбоотой хэргийн судалгаа

4.3 Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудал 74

ТАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ 77

НЭГ. ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

1.1 Мансууруулах бодис

“Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх бодис”-ын тодорхойлолтыг хууль зүй, анагаах ухаан, химийн зэрэг шинжлэх ухаануудын тус тусын тодорхой шалгууруудын үндсэн дээр гаргаж болдог.

Олон улсад болон манай оронд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн баримт бичгүүдэд дурдсанаас үзвэл “мансууруулах бодис” гэдэгт Мансууруулах эмийн тухай НҮБ-ын 1961 оны нэгдсэн конвенц (1972 оны протоколоор оруулсан нэмэлт, зааврын хамт), түүний 1, 2 дугаар жагсаалтад заасан эмийн найрлагаас агуулсан, байгалийн болон нийллэгжүүлж гаргаж авсан бөгөөд онцгой төрлийн мансууруулах үйлчилгээ үзүүлж, хүч тамир барагдуулдаг, удаан хэрэглэвэл сэтгэцийн өвчнөөр өвчлүүлдэг бодисуудыг хамааруулан ойлгодог билээ.

Наркологи буюу мансуурал судлалын үүднээс авч үзвэл бүх мансууруулах бодис сэтгэцэд нөлөөт бодис багтана. Мансууруулах бодисын тоонд бидний нэрлэж заншсанаар хар тамхи буюу опиумын гаралтай мансууруулах бодисууд мөн ордог. Хар тамхи гэдэг нь опиумуудад оноож өгсөн хар ярианы хэллэг бөгөөд албан ёсны баримт бичигт хэрэглэгдэх шинжлэх ухааны нэр томъёо биш юм.

Хүн амьдралдаа ямар нэг таашаал авахын тулд тодорхой нэг зүйлийг хийж, бүтээж, түүний төлөө хичээл зүтгэл гаргаж байж тэрхүү таашаалаа хүртдэг бол мансууруулах бодис нь энэ үйл явцыг эвдэж, ямар ч зүйл хийлгүйгээр дээд таашаал авч буй мэт мэдрэмж төрүүлдэг байна. Хар тамхи буюу narcotics нь “narcosis” гэх Грек үгээс гаралтай ба хөдөлгөөнгүй болон, нойронд автах, саажих гэсэн агуулгатай.

Мансууруулах бодисын төрлийг авч үзвэл:

Опиод: байгалийн болон синтетик гаралтай, өвчин намдаах, сэтгэл хэт ихээр хөдөлгөх, тайвшруулах болон хүнийг удаашралтын байдалд хүргэх үйлчилгээтэй. Байгалийн гаралтай опийгийн төрлийн мансууруулах бодис нь бүгд намуу цэцгээс гаралтай байдаг. Хүний биеийн бодис солилцох процесст оролцож, үүгээрээ хүний бие, сэтгэцэд хялбархан нөлөөлж, дуртай болгож, донтуулдаг байна. Уг төрлийн бодисууд нь хүний бие махбодь болон сэтгэцэд маш хүчтэй хор уршиг үзүүлдэг бөгөөд нөлөөнд нь автсан, донтсон хүнийг эмчлэхэд хүндрэлтэй байдаг. Эдгээр нь дотроо:

- *Ацетилированный опий.* Хэд хэдэн химийн урвалд оруулсны дараа гаргаж авдаг хэрэглэхэд бэлэн уусмал. Хар хүрэн өнгөтэй бөгөөд уксус шиг хурц үнэртэй.
- *Опийн түүхий эдшүүс.* Намуу ургамлаас тусгайлан гаргаж авсан шүүс бөгөөд ацетилированный опийн уусмал бэлдэхэд хэрэглэдэг. Уг бодис нь баримлын шавар шиг ба өнгө нь цагаанаас авахуулаад бор өнгөтэй байдаг, борлуулахдаа жижиг хэмжээний бөмбөлөг болгон зардаг.
- *Геройн.* Опийгийн төрлийн мансуурах бодис дунд хамгийн их дэлгэрсэн нь. Маш хүчтэй мансууруулах чадалтайгаас гадна их хэмжээний хордуулагчтай, түүнчлэн 2-3 удаа хэрэглэхэд донтох аюултай. Геройныг татдаг, хамраар сорох, үнэрлэж, судсандаа хийж хэрэглэдэг байна.
- *Намууны сүрэл.* Хатаасны дараах опиумын намууны бүх хэсгийг хэлнэ. Үүнийг ацетилированный опийгийн уусмал бэлдэхэд хэрэглэдэг.
- *Метадон.* Опийн төрлийн хүчтэй синтетик мансууруулах бодис юм. Зарагддаг хэлбэр нь цагаан өнгийн нунтаг болон бэлэн уусмал байдаг. Зарим орнуудад мансууруулах бодист донтогсдыг эмчлэхэд орлуулж хэрэглэдэг.



Зураг 1. Филиппины Манила хот дахь опиотоор мансуурагчид

Мансуурсны шинж тэмдэг нь дараах байдлаар илэрдэг. Үүнд: Хэт нойрмог байдалтай болох, сэтгэлийн хөдлөл ихсэх, удаашралтай ярих, ярианы явцаас хоцрох, сэдвээ ойлгохгүй байх, дуулгавартай болох /зарим тохиолдолд үг дуугүй захирагдах/, өдөр шөнийн аль ч цагт харанхуйд, ганцаараа, чимээгүй орчинд байхыг хүсэмжлэх, арьс цонхийх, хүүхэн хараа жижигрэх, мөн ойр орчмын гэрэлд хариу үйлдэл үзүүлэх боломжгүй болох, зүрхний цохилт удаашрах, өвчин мэдрэх чадвар буурах, хоол идэх, уух дуршил багасах, рефлекс болон бэлгийн дур хүсэл багасах зэрэг болно.

Энэ төрлийн мансууруулах бодисыг хэрэглэснээр хүний бие махбодид олон сөрөг үр дагавар бий болдог бөгөөд элэг үхжих, судасны өвчинд амархан өртөх, кальцын солилцоо муудсанаас шүд муудах, бэлгийн сулралд орох, оюун ухааны чадвар буурах зэргийг нэрлэж болно.

Амфетамин: сэтгэцийг цочроож, сэргээдэг энэ төрлийн мансууруулах бодист хиймэл, синтетик бодис агуулагддаг ба амфетамины нэгдэл орсон байдаг. Ихэвчлэн судсаар тарьдаг. Бусад эфедрин агуулсан эм, тарианаас гаргаж ирдэг. Амфетамины үйлчлэх хугацаа нь төрлөөсөө хамааран 2-12 цаг байдаг бөгөөд байнга хэрэглэх тусам хэмжээ/тунгаа

ихэсгэх шаардлагатай болдог. Бие махбодийн болон сэтгэцийн донд автуулдаг. Хэрэглэсэн үед уур уцаар ихсэх, амархан уурлах зэрэг ааш араншинтай болдог. Эдгээр нь дотроо:

- *Эфедрон*. Химийн урвал явагдсаны эцэст гардаг бүтээгдэхүүн. Ягаавтар, эсхүл тунгалаг уусмал байдаг. Нил цэцгийн үнэртэй төстэй.
- *Первитин*. Хэрэглэхэд бэлэн болсон уусмал байдаг, мөн л олон шат явуулсан химийн урвалын эцсийн бүтээгдэхүүн. Тослог, шаргал өнгийн, эсхүл тунгалаг өнгөтэй, алимтай төстэй үнэртэй. Геройны донтнуудыг эмчлэхэд орлуулж хэрэглэдэг ч илүү сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй байдаг.
- *Эфедрин*. Эфедра ургамлаас гаргаж авсан цагаан өнгийн талстууд байдаг. Мөн эмчилгээний зориулалттай хэрэглэдэг, бусад эм, бэлдмэлүүдтэй нийлүүлснээр эфедрон болон первитин гаргаж авдаг. Амьсгалж болон татаж хэрэглэнэ.

Мансуурсны шинж тэмдэг нь дараах байдлаар илэрдэг. Үүнд: Тайвшрах, сэтгэл таашаал ихээр мэдрэх, зүрхний хэмнэл хурдсах, цусны даралт ихсэх, хүүхэн хараа томрох, хэт их хөдөлгөөнд орох, бэлгийн чанартай зан үйл чөлөөтэй болох, чалчих, утга агуулгагүй нэг төрлийн үйлдэл давтан хийх, өлсөх мэдрэмжээ алдах, нойрны хэм алдагдах

Энэ төрлийн мансууруулах бодисыг хэрэглэснээр ХДХВ болон гепатит тусах өндөр магадлалтай болдог ба дархлааны систем муудахаас гадна дараах шинж тэмдэг илэрнэ: Хөлс их хэмжээгээр гарах, толгой эргэх, өвдөх, хараа муудах, зүрхний шигдээс болох, харвалт өгөх, мэдрэлийн хэт ядаргаанд орох, сэтгэцэд их хэмжээгээр өөрчлөлт орох, элэг устах.

Каннабис: дулаан бүсэд ургадаг ургамал бөгөөд урд зүгийн /илүү дулаан газар ургасан/ каннабист илүү их мансууруулах бодис агуулагддаг. Гол мансууруулах үйлчилгээтэй бодис нь каннабиноид юм. Үндсэн үйлчилгээ

нь хүний сэтгэхүйг өөрчилдөг. Өрөө тасалгаанд хэрэглэсний дараа урт хугацаагаар шатсан өвсний үнэр үлддэг, мөн үнэр нь хувцсанд шингэдэг.

Эдгээр нь дотроо:

- *Марихуана*. Каннабис ургамлын хатаасан болон хатаагаагүй өвс шиг хэсгийг нь хэлдэг. Цайвар ногоон хүрэн өнгөтэй, тус ургамлын навчин хэсэг болон цэцэглэдэг хэсгийг үрж жижиглэсэн байдаг, мөн жижиглэн бөмбөлөг болгосон байж болдог. Хэрэглэхдээ тамхи шиг ороож татаж болдог ба гаансанд хийж татах боломжтой, зарим тохиолдолд хоолонд хийж хэрэглэдэг. Нэг удаа марихуана татахад 25 янжуур татсантай адил хэмжээгээр мансуурдаг байна.

- *Гашиш*. Өөртөө 20 хүртэлх хувийн каннабиноид агуулж байдаг. Давирхай, цэцгийн тоос, ургамлын нунтагласан дээд хэсгүүдийг хольсон байдаг. Тусгай багаж хэрэгслээр татдаг. Үйлчилгээ нь 10-30 минутын дараа эхэлдэг ба удаан хугацаанд буюу нилээд хэдэн цаг үргэлжилдэг.



Зураг 2. Тусгайлан бэлтгэсэн гашиш

Мансуурсны шинж тэмдэг нь дараах байдлаар илэрдэг. Үүнд: Сэтгэл хэт ихээр хөдлөх, хайхрамжгүй болох, биеэ барих чадвар буурах, чалчаа болох, хэт өлссөн болон ам цангасан мэт мэтрэмж төрөх, өнгө, дуу чимээг нарийн мэдрэх, хүүхэн хараа томорч, гэрэл мэдрэмтгий болох, уур

уцаартай, омголон, эсхүл дээд зэргийн баяр баясгалантай болох, эд зүйлсийн хэмжээ болон орчинд байрлаж буйн хэмжигдэхүүний мэдрэмж нь үгүй болох, шалтгаангүйгээр айх, хий юм үзэж, харах, сонсох, мэдрэх,

Энэ төрлийн мансууруулах бодисыг хэрэглэснээр: бодол санаа цэгцгүй, гутранги болох, сэтгэл санааны дарамтад орох болон тайван бус болох, орчноос хязгаарлагдуулсан мэт санагдах, хөдөлгөөний хэвийн хэмжээ алдагдах, ой санамж болон оюун санаа хямрах, бэлгийн бойжилт, хөгжилт саарч, удаашрах, үрийн шингэн боловсруулах процесст өөрчлөлт орох, сарын тэмдэгийн мөчлөг алдагдах, тунг ихдүүлсэн тохиолдолд паранойтой болох, мөн хий юм харах, сонсох, мэдрэх тохиолдол гардаг, сэтгэцийн донтой болгодог ба илүү хүнд төрлийн мансууруулах бодис хэрэглэхийг өдөөж, давхар согтууруулах ундаа хэрэглэх дур хүслийг өдөөдөг, уушигны өвчин, бронхит, хорт хавдар тусах эрдэл ихэсдэг.

Экстаси: Амфетамин төрлийн синтетик мансууруулах бодисын ерөнхий нэр юм. Нүдэнд хий юм үзэгдэх, харагдах, сонсогдох шинж тэмдэг илэрдэг. Төрөл бүрийн өнгөтэй, ойролцоогоор 150 мг бодис байдаг. Энэ бодис нь өндөр үнэтэйд ордог ба хэрэглэгч нар нь героин болон амфетаминыг байнгын хэрэглээгээ болгосон байдаг.



Зураг 3 Экстаси нь төрөл бүрийн өнгөтэй, ойролцоогоор 150 мг бодис байдаг.

Мансуурсны шинж тэмдэг нь дараах байдлаар илэрдэг. Үүнд: Мансуурах үйлчилгээ нь 3-6 цаг үргэлжилдэг, мэдрэлийн төв системийг өдөөж, түлхэц өгдөг, бие махбодийн байдал идэвхжих, биеийн тэсвэр даах чадвар сайжрах, бяр хүчтэй мэт болдог.

Харин экстазийн үйлчилгээ дууссаны дараа гөлрөх, маш их ядрах, нойрмог болох зэрэг шинж тэмдэг илрэх ба энэ байдал нь олон хоногоор үргэлжилдэг байна.

Энэ төрлийн мансууруулах бодисыг хэрэглэснээр: Сэтгэлийн гүн гутралд орсноор амиа хорлоход хүргэж болно. Бие махбодийн болон сэтгэл мэдрэлийн сульдалт болон ядаргаанд оруулдаг, мэдрэлийн систем доголддог, зүрх, элэг зэрэг эрхтний хэвийн үйл ажиллагаа алдагддаг, бусад дотор эрхтнүүд тэжээлийн хомсдолд ордог, генийн бүтэц, кодоод өөрчлөлт оруулдаг

Улмаар усгүйжилт болон шингэний дутагдал, бие организм ачааллаа даахгүй улмаас болон бөөрний хурц дутагдлаас үүдэн нас барах эрсдэл өндөр болдог байна.

Галлюциноген: химийн бүтцийн хувьд тогтсон эх үүсвэр байхгүй, хүний сэтгэцэд төрөл бүрээр нөлөөлдөг, тухайлбал хий юм үзэж, харж, сонсож, орчноо хүлээн авч, гаргах зан авир, араншин, бодол санаа зэрэгт өөрчлөлт оруулдаг.

Эдгээр нь дотроо:

- *ЛСД.* Синтетик мансууруулах бодис бөгөөд лазергийн хүчлээс гаралтай. Амтгүй, үнэргүй, өнгөгүй нунтаг ба шингэн хэлбэртэй байж болдог. 30-60 минутын дараа үйлчилж эхэлдэг ба 12 цаг хүртэлх хугацаанд үргэлжилдэг. Маш бага хэмжээгээр хэрэглэдэг атлаа галлюцинаци буюу хий юм үзэж харах, сонсох мэдрэх нь их хүчтэй байдаг.



Зураг 4 LSD буюу ЛСД нь нимгэн, төрөл бүрийн зураг, дүрстэй үйлдвэрлэгддэг.

- *Псилоцин ба псилоцибин.* Хий юм харж, сонсох, мэдрүүлэх үйлчилгээтэй мансууруулах бодис ба хортой мөөгөнд байдаг. Мансуурахад 2 гр хатаасан мөөг хангалттай байдаг. Энэ төрлийн мансууруулах бодисын гол аюул нь түүний олдоц их байдаг явдал юм.

Мансуурсны шинж тэмдэг нь дараах байдлаар илэрдэг. Үүнд: Цусны даралт өндөрсөх, хүүхэн хараа томрох, гар салгалах, арьс хуурайших, орчин тойрноо хүлээж авах мэдрэмж өөрчлөгддөг. Жишээ нь: Дуу, авиа сонсох, өнгө мэдрэх,галлюцинац, хэт их аз жаргалтай болох, сэтгэл санаа тогтворгүй болох, догдлох, өөрийн биеэ мэдэрч чадахгүй болох зэрэг болно.

Энэ төрлийн мансууруулах бодисыг хэрэглэснээр:

- Хүний уураг тархинд дахин нөхөгдөшгүй өөрчлөлт орох, сэтгэлзүйн гажилт үүсэх
- ЛСД-ыг нэг удаа хэрэглэсэн ч генийн бүтэц болон кодоод өөрчлөлт ордог ба тархинд хуримтлагддаг
- Хэрэглэсэн бодисын төрлөөс нь хамааран 2-12 цаг үйлчилдэг

- Сэтгэлзүйгээр болон бие махбодийг донтуулдаг
- Байнга хэрэглэснээр хэрэглэх хэмжээг ихэсгэх шаардлагатай болдог

Кокайн: кока ургамлаас гаргаж авдаг, сэтгэцийг өөрчилдөг мансууруулах бодис юм. Нүдний хэсгээс цээж хүртэл мэдрэмжгүй болгож, бие махбод үндсэндээ мэдрэмжээ алддаг.

Эдгээр нь дотроо:

- *Кокайн.* Цагаан өнгийн талстан бэлдмэл. Гуурсны тусламжтай хамраар сорж хэрэглэдэг. Усанд амархан уусдаг тул хамраар сорохоос гадна, уусгаж уух болон судсаар тарих боломжтой.

- *Крек.* Нимгэн хавтгайлсан зүйл байдаг. Үүнийг гаргаж авахдаа кокаин, хүнсний сод, ус зэргийг хольж ууршуулдаг байна. Крекийг татаж хэрэглэдэг ба үүнийг хэрэглээд маш амархан донтож болдог.



Зураг 5 Кокайныг гуурсны тусламжтай хамраар сорж хэрэглэдэг.

Мансуурсны шинж тэмдэг нь дараах байдлаар илэрдэг. Үүнд: Богино хугацаанд сэтгэлийн их хэмжээний таашаал өгдөг, ажиллах чадварыг дээшлүүлдэг, төв мэдрэлийн системд сэрэл өгдөг, амьсгал, цусны даралт, хөлс ялгаралтыг

ихэсгэдэг, хүүхэн хараа томордог, хоол идэх дур байхгүй болох, сэтгэл догдолсон байдалтай байх, нойргүй болох зэрэг болно.

Хэрэглэсний үр дагавар: зүрхний хэм алдагдах, хамраас цус гарах болон хамрын хэсэгт гэмтэл авах, салстын хэвийн байдал алдагдах, үнэрлэх, амтлах мэдрэмж байхгүй болох, сонсголын бэрхшээлтэй болох, параной сэтгэцийн өөрчлөлт орох, хий юм үзэх, харах, сонсох, мэдрэх, уур уцаартай болох, зүрхний үйл ажиллагаа алдагдсанаас болж нас барах эрсдэлтэй.

Ингальянты: ууршдаг мансууруулах бодис юм. Уг бодис нь ахуйн зориулалтаар голдуу хэрэглэгддэг. Жишээ нь: будаг, уусгагч, цавуу, шатахуун, үсний лак, хорхой шавьж устгах зориулалтаар үйлдвэрлэгддэг. Жирийн, энгийн нөхцөлд тус бодис нь мансууруулах бодист хамаардаггүй ч их хэмжээгээр хүний биед орсон тохиолдолд мансууруулах чадвартай байдаг.

Мансуурсны шинж тэмдэг нь дараах байдлаар илэрдэг. Үүнд: Галлюцинац үүсэх, хөдөлгөөний хэвийн үйл ажиллагаа алдагдах зэрэг болно.

Хэрэглэсний үр дагавар:

- найтаах, ханиах
- ханиад хүрэх, хамраас цус гарах
- дотор муухай оргих
- зүрхний хэмнэл алдагдах
- цээж хэсэгт өвдөх, зовиуртай байх
- хөдөлгөөний хэв маяг, тэнцвэр, чадавхи алдах
- хурц хордлогод орох, зарим тохиолдолд үхэж болзошгүй
- 8-10 сарын дотор элгийг хүнд хордлогод оруулдаг
- Уураг тархинд ихээхэн хор хөнөөл учруулдаг
- Хүнд хэлбэрийн хатгаа тусах эрсдэл өндөр болдог

- зан төрх өөрчлөгддөг
- оюун ухааны хөгжлийг сааруулж, зогсоодог

Нойрны эм: тайвшруулах болон нойр хүргэх эм бөгөөд хуулийн дагуу үйлдвэрлэгдсэн байдаг. Дотроо барбатураны хүчил агуулсан нь хамгийн аюултай. Нойрны эм нь бие махбодийн болон сэтгэцийн донтой болгох аюултай байдаг. Үүнийг архидан согтууруулах ундаатай хавсаргаж хэрэглэх нь эрүүл мэндэд их хэмжээний хор уршиг учруулдаг.

Мансуурсны шинж тэмдэг нь дараах байдлаар илэрдэг. Үүнд: Эргэлзэх, тээнэгэлзэх, хэл яриа ойлгомжгүй болох, уур уцаар ихсэх, бусдыг басамжлах, сэтгэлээр унах зэрэг.

Хэрэглэсний үр дагавар: Нойргүйдэх, тархи гэмтэх, эпилепстэй төстэй шинж тэмдэг илрэх, хүн мөрдөж, тагнаж байгаа мэт санагдах, зүрхний дутагдалд орох, элэгний тэжээлийн хомсдолд орох, тун ихдүүлэх, эсвэл гэнэт их хэмжээгээр тунг багасгаснаас болж нас барах

1.2 Сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис

“Сэтгэцэд нөлөөлөх бодис” гэдэгт сэтгэцэд нөлөөт бодисын тухай НҮБ-ын 1971 оны Конвенцийн 1, 2, 3, 4-р хавсралтад орсон байгалийн болон нийтлэг аливаа бодисуудыг ойлгоно.

Эмх замбараагүй хэрэглээнээс бий болох эрүүл мэндийн болон нийгмийн сөрөг үр дагаврыг харгалзан, мансууруулах үйлчилгээтэй бодис болохыг нь тогтоож, хяналтаас гадуур (эмнэлэг, судалгаа шинжилгээний бус зорилгоор) хэрэглэхийг хориглон, тусгай жагсаалтад оруулсан бодис, эм, бэлдмэлүүдийг хууль эрх зүйн үүднээс мансууруулах буюу сэтгэцэд нөлөөт бодис хэмээн тооцдог.

Нийгмийн талаас нь авч үзвэл хэрэглэсэн хэнийг ч зан үйлийн болон ёс суртахууны зөрчил рүү түлхэн, улмаар гэмт хэрэг үйлдэхэд хүргэж, нийгэмд нөхөгдөшгүй гарз учруулах чадавхи бүхий бодис, түүнийг агуулсан эм, бэлдмэлүүдийг

мансууруулах буюу сэтгэцэд нөлөөт бодис гэж үзэж болно.

Хэрэглэсэн хүний уураг тархинд давамгайлан нөлөөлж, эсвэл төв мэдрэлийн системийн үйл ажиллагааг цочроож, сэтгэцийн хөөрлийг сэтгэлийн баясал (эйфор)-ыг, бас хий үзэгдэл буюу бусад цагаан солио үүсгэх, эсвэл төв мэдрэлийн системийн үйл ажиллагааг дарангуйлж (саатуулж) булчин сулруулах, нойр хүргэх, мэдрэл тайвшруулах, сэтгэлийн түгшүүрийг номхотгох зэрэг үйлчлэлийг үзүүлэх чадварыг өөртөө шингээсэн хийгээд эмнэлэгийн бус зориулалтаар тогтмол хэрэглэвээс байн байн хүртэхийг шаардсан эмгэг хэрэгцээ (хүсэл)-ийг буй болгож “сэтгэлийг баясгах мэдрэлийг тайвшруулан мансууруулах” хэлбэрээр хүний бие сэтгэцийг эрхшээлдээ оруулах далд чадавхийг өөртөө агуулсан эм бодисуудыг сэтгэц идэвхит бодис гэж тооцно¹.

Дээрх тодорхойлолтуудад дурдсанаар сэтгэцэд нөлөөт бодис гэдэгт байгалийн гаралтай болон нийллэгжүүлэх аргаар гарган авсан, химийн тодорхой бүтэц, шинж чанар бүхий дан бодис, эсвэл тэдгээрийг агуулсан хольц, холимогууд хамаарна. Өөрөөр хэлбэл, эдгээр бодисууд нь юуны түрүүнд химийн хувьд тодорхойлогдсон байх ёстой юм.

1.3 НҮБ-аас мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой асуудлаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

НҮБ байгууллагдахаас өмнө мансууруулах бодистой холбоотой асуудлаар олон улсын түвшинд олон бэрхшээл хүндрэл үүсч байв. Эдгээр асуудлыг шийдэхийн тулд Үндэстнүүдийн Лиг (League of Nations) болон бүс нутгийн арга хэмжээ авах зорилгоор 20-р зууны эхээр хэд хэдэн гэрээ, конвенцийг баталсан байдаг. Эдгээр гэрээ, конвенцууд нь 1961 он хүртэл хүчинтэй байсан бөгөөд 1961 онд НҮБ-ын мансууруулах бодисын эсрэг урд өмнө гаргаж байсан бүх конвенцуудыг нэгтгэн Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенцийг баталсан юм.

¹ С.Бямбасүрэн “Мансуурал судлал” 1-р хэсэг, Улаанбаатар хот, 1999 он.

Мөн 1963 онд Намуу цэцгийг тариалуулах, опиумыг үйлдвэрлэх, олон улсын болон бөөний худалдаанд гаргахыг хязгаарлах болон зохицуулах тухай протокол хүчин төгөлдөр болсон юм. Анх 1953 онд гарын үсэг зурж баталгаажуулсан хэдий ч 10 жилийн дараа л хүчин төгөлдөр болох нөхцөл нь бүрдсэн байдаг.

1960-аад оны дундуур баруун Европт шинэ төрлийн сэтгэцэд нөлөөлөх бодис дэлгэрч, тэдгээрийг 1961 оны конвенцоор зохицуулах боломжгүй байсан бөгөөд 1971 онд Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенцийг баталснаар, шинээр гарч ирсэн тэдгээр бодисуудыг олон улсын хэмжээнд зохицуулах үндэс тавигдсан юм.

Мөн 1972 болон 1973 онуудад 1961 оны Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенцид заагдаагүй болон нэмэлт тодруулга хэрэгтэй зүйлсийг нэмж тодотгон зааснаар хариуцлага, шийтгэлийн талаар илүү тодорхой зохицуулжээ.

Мансууруулах бодисын араас дагалддаг өвчин бол ХДХВ/ДОХ, элэгний В,С вирусууд байдаг. Учир нь мансууруулах бодисыг тариагаар хэрэглэдэг хүмүүс нь зүү, тариаг ариутгахгүй, өөрсдийн аюулгүй байдлаа хайхрахгүйгээс болж халвар авдаг байна. Мөн тарианаас бус, мансууруулах бодис хэрэглэдэг хүмүүс нь мансуурч, эрүүлээр сэтгэх чадваргүй болдог бэлгийн замын эрсдэлтэй зан үйлдэл хийж, мөн л дээрх өвчнөөр халдварлах эрсдэлд ордог байна. Тиймээс 1986 оноос дэлхий нийтээр ДОХ-той тэмцэх хөдөлгөөнийг НҮБ-ын оролцоотой өрнүүлэх болжээ.

Мансууруулах бодисын хэрэглээ ихэссэнээр тээвэрлэлт, борлуулалт гэх мэт хууль бус үйлдлүүд дэлгэрч нэг улсын газар нутгаар хязгаарлагдахаа больж хар тамхи бий болохоос авахуулаад эцсийн хэрэглэгчид хүрэхэд олон шат дараалалтай, олон орон нутгийг хамрах болсон байна. Тиймээс улс орнуудын хамтын үйл ажиллагаа болон уялдаа холбоог сайжруулах зорилгоор 1988 онд Мансууруулах эм сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн тухай

конвенцийг НҮБ-аас баталсан юм. Мөн хар тамхийг хэтрүүлэн хэрэглэх ба хууль бус тээвэрлэлтийн эсрэг олон улсын өдрийг жил бүрийн 6 дугаар сарын 26-ны өдөр тэмдэглэж байна.

Мөн 1997 онд НҮБ-ын хар тамхи болон гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага /UN Office on Drugs and Crime/ байгуулагдсан бөгөөд энэ нь мансууруулах бодис болон түүнтэй холбоотой гэмт хэрэгтэй тэмцэхэд анхаарлаа хандуулж ажилладаг НҮБ-ын тусгай байгууллага юм. Дэлхийн хар тамхины нөхцөл байдлыг жил бүр тайлагнадаг ба үүнээс дэлхийн улс орнууд дахь нөхцөл байдал, хар тамхины тархац зэргийг харж болох юм.

1998 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн хар тамхины талаарх тусгай хуралдаанаар хар тамхины талаар баримтлах 10 жилийн стратегийн төлөвлөгөө боловсруулсан хэдий ч үр дүнгээ өгөөгүй юм.

НҮБ Хар тамхины удирдах зарчим ба хар тамхины хэрэглээг багасгах тунхагийг 1999 онд баталсан байна. 2000 онд НҮБ-ын Мянганы хөгжлийн зорилтод мансууруулах бодистой тэмцэх үйл ажиллагааг нэр заан оруулаагүй хэдий ч тавьсан зорилгууд нь биеллээ олох тохиолдолд нийгэм дэх мансууруулах бодисын талаарх ойлголт өөрчлөгдөж үүнтэй холбоотойгоор мансууруулах бодисын хэрэглээ нь багсах боломжтой гэж үздэг.

2008 онд НҮБ-ын хар тамхи болон гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага ба Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллага хамтран Хар тамхины донтнуудыг эмчлэх зарчмуудыг баталжээ. Учир нь мансууруулах бодистой тэмцэх үйл явцад хар тамхинд донтсон хүмүүсийг олон талаас нь авч үзэж, эмчилж, эмчилгээгээ хүртээмжтэй байлгахыг эрмэлзэж, тус зарчмуудыг бусад улс орнууд өөрсдийн удирдамж болгон хар тамхичдыг эмчлэх явдлыг санал болгосон байна.

ХОЁР. ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, КОНВЕНЦООР ЗОХИЦУУЛСАН НЬ

Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц /1961/, Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц /1971/, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц /1988/-ууд нь харилцан уялдаатай бөгөөд сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хянах эрх зүйн орчин, механизмыг бүрдүүлсэн олон улсын үндсэн гэрээ хэлэлцээрүүд юм.

1961 болон 1971 оны конвенцуудын гол зорилго нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг анагаах ухаан болон эрдэм шинжилгээний зорилгоор хэрэглэхийг² хорихгүйгээр, харин тус бодисуудтай холбоотой хууль бус үйлдлүүдийг³ таслан зогсоох болон урьдчилан сэргийлэхэд чиглэсэн болно. Харин 1988 оны конвенцийг өмнөх хоёр конвенцийн нэмэлт хэрэгсэл хэмээн ойлгож болно.

2.1 НҮБ-ЫН 1961 ОНЫ МАНСУУРУУЛАХ ЭМИЙН ТУХАЙ НЭГДСЭН КОНВЕНЦ

Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенцийг батлах чуулга уулзалт Нью-Йорк хотод НҮБ-ын төв байранд 1961 оны 01 дүгээр сарын 24-өөс 03 дугаар сарын 25-ныг хүртэлх хугацаанд хуралдаж тус конвенцийг баталжээ. Уг чуулга

² 1961 оны конвенцийн 4-р зүйл, 1971 оны конвенцийн 5-р зүйл

³ Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенцийн 36 дугаар зүйлийн дагуу Шийтгэлийн тухай заалт 1а) Тал бүр энэхүү конвенцийн заалтуудыг зөрчиж мансууруулах эм тарималжуулах, үйлдвэрлэх, бэлтгэх, гаргаж авах, бэлдэх, эзэмших, санал болгох, худалдахаар санал болгох, түгээх, худалдан авах, худалдах, аливаа нөхцлөөр хүргүүлэх, зуулчилах, илгээх, дамжин өнгөрүүлэн илгээх, тээвэрлэх, импортлох болон экспортлох, түүнчлэн тухайн талын үзэж байгаагаар энэхүү конвенцэд харш байж болох аливаа бусад үйлдлийг санаатайгаар үйлдсэн бол шийтгэвэл зохих гэмт хэрэг гэж үзэх, мөн ноцтой гэмт хэрэгт тохирох шийтгэл, тухайлбал хорих буюу эрх чөлөөг нь хасах бусад шийтгэл хүлээлгэх явдлыг хангах арга хэмжээг өөрийн үндсэн хуулийн хязгаарлалтыг харгалзан авна.

Мөн сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенцийн 22-р зүйл д мөн заасан байдаг.

уулзалтад нийт 75 улс орон оролцсон байдаг.

Чуулганаас Нэгдсэн конвенцийн хэрэгжилтийг хангах байнгын хороо байгуулахаар тогтож Ерөнхий хороо ба конвенцийн холбогдох зүйлүүдэд заагдсан харилцааг зохицуулах үүрэг бүхий 9 дэд хороо, Техникийн, Төслийн ба Итгэмжлэлийн гэсэн 3 дэд хорооны бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулахаар шийдвэрлэж байв.

Тус конвенцоор хоёр үндсэн асуудлыг авч үзсэн байна. Үүнд:

- Хуулийн дагуу хэрхэн хэрэглэх талаар
- Хууль бусаар хэрэглэхгүй байх талаар авах арга хэмжээний талаар

Уг конвенцоор мансууруулах бодисын жагсаалтыг баталсан бөгөөд элсэн орсон улс орнууд дотооддоо энэхүү жагсаалтад мансууруулах бодисыг нэмэх боломжтой юм. Конвенцийн бусад онцлог шинжийг дурдвал:

- Хуулийн дагуу хэрэглэх хар тамхины хэмжээг хэрхэн тооцоолохыг болон түүнд хэрхэн хяналт тавих талаар тусгасан;
- Улс болгон дотоодын хяналтийн систем бий болгох ёстой;
- Хар тамхитай холбоотой үйл ажиллагаанд ашиглагдсан техник, тоног төхөөрөмжүүд хураагдах ёстой;

Конвенцид заагдаагүй зарим асуудлыг 1973 онд гарсан 1961 оны конвенцийн тайлбар буюу Commentary on the Convention (1961)-д тодруулсан байдаг. Жишээ нь: Хэн нэгэн этгээд өөрийн хувийн хэрэглээнд зориулж мансууруулах бодис хадгалж байсныг гэмт хэрэгт тооцохгүй, харин зарж борлуулах зорилгоор хадгалж байсан бол гэмт хэрэгт тооцон хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан байдаг. Хариуцлагын хэм хэмжээг улс орнууд өөрсдөө тодорхойлох бөгөөд хувийн хэрэглээгээ хангах зорилгоор хадгалж байсан хүнд хариуцлага тооцох

бол хорьж болохгүй бөгөөд зөвхөн захиргааны хариуцлага хүлээлгэх боломжтой байхаар зохицуулсан байдаг.

Уг конвенцийн бас нэг чухал өөрчлөлт нь 1972 оны конвенцид өөрчлөлт оруулах тухай протокол юм. Үүний гол агуулга нь шийтгүүлж байгаа хүнд хорих, эсхүл албадан эмчилгээ хийх, аль эсвэл хорихоос гадна давхар эмчилгээ хийх шийтгэл ногдуулах боломжтой болсон явдал юм.

2.2 НҮБ-ын 1971 оны Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц

1960-аад оны дунд үеэс баруун Европийн орнуудад шинэ төрлийн мансууруулах бодис өргөнөөр дэлгэрсэн бөгөөд тэдгээрийг 1961 оны конвенцийн дагуу олон улсын хэмжээнд зохицуулаагүй гэж үзсэн болно. Иймд Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенцоор уг шинэ төрлийн мансууруулах бодисыг олон улсын хэмжээнд зохицуулах шаардлага гарчээ.

Улмаар 1971 оны 02 дугаар сарын 21-ны өдөр Австрийн Вена хотод Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенцийг баталсан бөгөөд уг конвенцид 1961 оны конвенцид багтаагүй мансууруулах бодисуудыг нэгтгэн нийт 4 жагсаалт гарган 1 дүгээр жагсаалтад орсон бодисыг хатуу хяналтад авч, хэрэглэхийг хориглох талаас нь оролцогч орнууд арга хэмжээ авах, мөн 2,3,4 дүгээр жагсаалтад орсон бодисыг мөн хяналтад авч зөвхөн эмчийн жороор олгож байхаар зохицуулжээ.

Одоогоор энэхүү конвенцид нийт 175 улс нэгдэн ороод байна. Харин манай улсын тухайд тус конвенцид 1999 онд нэгдэн орсон болно.

Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц батлагдсанаар түүний буруу хэрэглээ, хууль бус үйлдвэрлэл, эргэлтэд хяналт тавих, хязгаарлах, хүн амыг хорт зуршлаас хамгаалахад чиглэгдсэн олон улсын эрх зүйн орчин бүрдсэн юм.

2.3 НҮБ-ын 1988 оны Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц

1988 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц нь 1961 болон 1971 оны конвенцүүдыг нөхөх нэмэлт хэрэгсэл болсон юм. Уг конвенцийн зорилго нь хар тамхи болон түүнтэй холбоотой хууль бус үйл ажиллагааг таслан зогсооход олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чиглэдэг.

Конвенц нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын хяналтын тогтолцоо, хууль бус эргэлтийн эсрэг авах арга хэмжээний талаар, түүнтэй холбоотой мөнгө угаах үйл ажиллагааг зогсоох, эрүүгийн эрх зүйн асуудлаар олон улсын хамтын ажиллагааг сайжруулах зэрэг зорилтуудыг тавьсан бөгөөд өмнөх конвенцуудыг үр дүнд хүргэхэд арга барил, механизм, тогтолцооны үүднээс туслахад чиглэсэн гэж ойлгож болно. Түүнчлэн мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодист тавих хяналт, олон улсын хороод болон мансууруулах бодистой тэмцэх комиссуудад дээрх гурван конвенцоор үйл ажиллагааны чиг үүргийг нь тодорхойлсон байна. Тухайлбал мансууруулах бодистой тэмцэх комисс нь мансууруулах бодистой холбоотой асуудлуудыг шийдвэрлэдэг гол байгууллага ба тус асуудлыг⁴ үр дүнтэй шийдвэрлэхэд Зөвлөлийн тогтоолоор дамжуулан НҮБ-ын Ерөнхий Ассамблей шинээр зохицуулах арга хэмжээ, эсвэл шинэ удирдах зарчмуудыг батлан гаргадаг.⁵

Өөр нэг хяналтын байгууллага бол Мансууруулах бодист хяналт тавих олон улсын Хороо юм. Тус хороо нь олон улсын чанартай гэрээ, конвенцийн биелэлтийг хянан шинжиж, шаардлагатай үед улс орнуудад зөвлөмж өгдөг. Түүнчлэн уг байгууллага нь бусад улс орны Засгийн газраас илгээсэн мэдээ мэдээлэл дээр үндэслэн статистикийн хяналт тавьж,

⁴ Жишээ нь хар тамхийн хууль бус эргэлт, түүний хэрэглээ ба хэрэглээний хандлага /тухайн газар нутаг, улс орон, дэлхийн хэрэглээ/

⁵ Тус жагсаалтад өөрчлөлт оруулах эсэхийг шийддэг

мансууруулах бодисын зөвшөөрөгдсөн хэмжээний үйдвэрлэл ба түүнтэй холбоотой үйл ажиллагааг зохицуулдаг.

Монгол Улс нь дээрх гурван конвенцид нэгдэн орсноор олон улсын хэмжээнд мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлийн хууль бус эргэлттэй тэмцэх үүрэг хариуцлага хүлээж түүнийгээ гүйцэтгэх зорилгоор үндэсний хууль тогтоомжийг уг конвенцуудтай нийцүүлж мансууруулах бодис болон түүнтэй холбоотой үйл ажиллагааг таслан зогсоох үүрэг хүлээж байгаа болно.

Эдгээр конвенцуудыг батлах үед хар тамхи хэрэглэх болсон цаад учир шалтгааныг нь судлахаас илүүтэй хар тамхинд хатуу хязгаарлалт тавих нь илүү чухал байв. Тиймээс зохицуулагдаж байгаа зүйл нь мансууруулах бодис болохгүй ба эдгээрийг зөвхөн эмнэлэгийн зориулалтаар болон шинжлэх ухааны зорилгоор хэрэглэхийг дэмждэг. Мөн тус конвенцуудын чухалчлан хамгаалж байгаа объект нь хүн, хүн амын болон нийгмийн эрүүл мэнд юм.

ГУРАВ. ДЭЛХИЙН БУСАД УЛСЫН ТУРШЛАГА

3.1 Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын эрх зүйн зохицуулалтын товч түүх⁶

Мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын эрх зүйн зохицуулалтын түүхийг үндсэндээ 3 үе болгон ангилж болох юм. Үүнд:

1. 1800-1959 он /Каннабис, опиумын хэрэглээг хуулиар зохицуулж, мансууруулах бодисыг нийлэгжүүлсэнээр эмчилгээнд хэрэглэж эхэлсэн үе/
2. 1960-1996 /Аюултай мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын хууль бус эргэлт газар авч, НҮБ-ын 3 конвенц

⁶ “A History of Drug Prohibition,” Transform Drug Policy Foundation, 2013 оны 3 сарын 8-нд татаж авсан http://www.tdpf.org.uk/Policy_Timeline.htm.

батлагдаж, хориглох, эсэргүүцлийн арга хэмжээ өрнөсөн үе/

3. 1997-2007 /Өмнөх арга хэмжээнд дүгнэлт өгч, шинэ стратеги, эрх зүйн орчинг бий болгосон үе/.

3.1.1 1800-1959 оны эрх зүйн зохицуулалт

1800 онд Наполеон Египетэд дайтаж байхдаа өөрийн цэргүүддээ каннабисын⁷ ургамал хэрэглэхийг хориглосон зарлиг гаргасан бол 1858 онд Нэгдсэн Вант Улсад Хорын тухай хууль /Passage of the Poisons Act/-ийг гаргаж, хүний амийг хөнөөх зорилгоор хор өгөх, нийлүүлэхийг⁸ хориглосон хууль гарсан нь орчин цагийн мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой эрх зүйн үндсийг тавьсан юм.

1860 онд Хятад, Их Британи, АНУ-ыг хамарсан Бээжингийн Конвенц, 1875 онд АНУ-д Сан Францискогийн опиумын⁹ тухай хуулийг баталсан байна. Эдгээр эрх зүйн баримт бичиг нь опиумын хэрэглээг зохицуулсан ч, ялгаварлан гадуурхсан шинжтэй байжээ. Тухайлбал, Америкт опиумын хэрэглээ нэмэгдэж байгаад цагаач хятад иргэд л буруутай бөгөөд тэднийг хориглосон өнгө аястай байсан бол Сан Францискогийн опиумын тухай хууль нь цагаан арьстан хүний хэрэглээг орхигдуулсан байна.

1912 онд Германд цус бүлэгнүүлэхэд хэрэглэдэг бодис гарган авахын тулд мансууруулах бодисыг нийллэгжүүлж, эмчилгээнд ашиглах боломжийг нээжээ. Олон улсын анхны опиумын хурал Нидерландын Гааг хотноо болж, Гаагийн конвенцийг баталж, опиумыг эмчилгээний зорилгоор хэрэглэх

⁷ Олсны овгийн бүх төрлийн ургамал /марихуан, гашиш, гашишийн тос гэх мэт/.1988 оны мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенц/. Амаар татах, уух, идэх зэргээр хэрэглэдэг.

⁸ Хор өгч хүний амийг хөнөөх гэж буй алуурчины гарт өгөхийг хориглоно гэсэн утгатай байжээ.

⁹ Опиумын намуу гэж *Papaver somniferum* L зүйлийн ургамлыг хэлнэ. Опиум нь морфин, героин болон бусад бодисыг гарган авах гол түүхий эд болдог.

явдалд хязгаар тогтоож, зөвшөөрөлгүйгээр эзэмшвэл хариуцлага хүлээх, зөвшөөрөлгүй этгээдэд худалдахыг хоригложээ.

Германд 1942 онд “метадон”¹⁰-ны патент авч улмаар 1947 оноос АНУ-д удаан үйлчилгээтэй, хямд өртөгтэй мэдээ алдуулагч болгон үйлдвэрлэж, түгээж эхэлсэн байдаг.

3.1.2 1960-1996 оны эрх зүйн зохицуулалт

1961 онд НҮБ-ын Мансууруулах эмийн тухай конвенц батлагдаж, эмнэлгийн болон судалгааны зорилгоос бусад тохиолдолд опиод, каннабинойд ба кокаиныг хориглож, бодисуудыг 1-4 дүгээр жагсаалтад оруулсан бол 1971 онд Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенцийг баталж, шинэ бодисуудыг оруулж, өргөжүүлсэн. 1988 онд Мансууруулах ба сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц батлагдаж, олон улсын хамтын ажиллагааны зарчмуудыг тодорхойлжээ.

Энэ үед олон нийтийн дунд мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис улам тархаж, хориглосон болон эсэргүүцлийн ажиллагаа идэвхжсэн байна. Тухайлбал, АНУ-д 13 настай охин төрсөн өдрөөрөө найзуудтайгаа марихуана хэрэглэсэн нь илэрч, өсвөр насныхныг мансууруулах бодис хэрэглэхийг эсэргүүцсэн эцэг эхчүүдийн хөдөлгөөн өрнөжээ. 1984 онд Рейганы засаг захиргаанаас хар тамхины эсрэг “Үгүй гэж хэл” нэртэй компант ажлыг өрнүүлж, 1990 онд Ерөнхийлөгч Буш мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой тэмцэх, хуулийг хэрэгжүүлэх зорилгоор төсвийг 50% буюу 1.2 тэрбум доллараар нэмэгдүүлж байлаа.

¹⁰ Удаан хугацааны үйлчилгээтэй синтетик мансууруулах үйлчилгээтэй өвчин намдаагч.

3.1.3 1997-2006 оны эрх зүйн зохицуулалт

Энэ үед мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын талаар өмнө авч хэрэгжүүлсэн арга хэмжээг дүгнэж, шинэ стратегийг бий болгосон юм. Тухайлбал, 1998 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын талаар тусгай хуралдааныг хийж “.....хар тамхины тариалалт, ургацын хэмжээг үлэмж бууруулсанаар 2008 он гэхэд мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын эсрэг томоохон ахиц дэвшил гаргасан байх” тухай дурджээ.

Олон оронд мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын талаар авч хэрэгжүүлж байгаа сүүлийн 10 жилийн бодлогод дүн шинжилгээ хийж, хуульд өөрчлөлт оруулж, бүтцийн шинэчлэл хийжээ. Тухайлбал, Португалд хувийн хэрэгцээний зориулалтаар мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хэрэглэхийг зөвшөөрсөн заалтыг оруулсан бол Канадад бага хэмжээний каннабист шүүхээр шийтгэл оногдуулахгүй болгосон байна.

3.2 Хэрэглэгч, жижиглэн худалдаалагч нарт захиргааны хариуцлага тооцож зөвхөн зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэж буй орнууд

3.2.1 АНУ-ын мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын эрх зүйн зохицуулалт, ялын бодлого

АНУ-ын мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг зохицуулсан хууль эрх зүйн үндэс 1860-аад оноос эхтэй ч 1909 онд АНУ-ын Опиумын эсрэг хууль (Passage of the US Opium Exclusion Act), 1914 онд Харрисоны¹¹ мансууруулах бодисын тухай хууль гарснаар

¹¹ Опиумын төрлийн ургамлыг үйлдвэрлэх, имтортлох, түгээхийг хуульчилж, татвар ноогдуулсан хууль. АНУ-ын Конгрессын гишүүн Францис Буртон Харрисон анх энэхүү хуулийг санаачилж, 1914 онд батлагдсан.

кокайн, героин, опиумын төрлийн бодист шошго наах, татвар ногдуулах тухай харилцааг зохицуулсан байна.

1970-аад оны эхээр АНУ-ын Ерөнхийлөгч Ричард Никсон “Хар тамхины эсрэг дайн”-ыг зарлаж, эрх зүйн цогц бодлого явуулсан юм. 1970 онд АНУ-ын Конгресс “Мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэх, хянах тухай цогц хууль” (Passage of the Comprehensive Drug Abuse Prevention and Control Act)–ийг баталсан ба энэхүү хууль нь өмнө гарч байсан олон хууль, дүрмийг нэгтгэн цогц байдлаар хандсан, тухайлбал, мансууруулах бодисын үйлдвэрлэл, түгээлтийг зохицуулахаас гадна төв мэдрэлийн системийг өдөөгч бодис, төв мэдрэлийн системийг дарангуйлагч бодис, солио үүсгэгч /хий юмс үзэгдүүлж, сонсогдуулагч бодис/, булчинг чадавхжуулагч, химийн найрлага зэргээр нь ангилсан байна. мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хянах, тухайн ангилалд нэмж оруулах бодис, хяналтын бүртгэлээс хасах, ангиллыг өөрчлөх, нэг ангиллаас нөгөө ангилалд хэрхэн шилжүүлэхтэй холбоотой механизмыг зааж өгчээ.

Уг хууль хяналтын бүртгэлд орсон мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын эмийн болон донтоход нөлөөлөх байдлаар нь 5 ангилалд оруулсан.

I дэх ангилалд хамгийн их хор нөлөөтэй бөгөөд эрүүл мэндийн салбарт хэрэглэж болохгүй, хувь хүний аюулгүй байдалд яаж ч нөлөөлж болохуйц бодисыг оруулсан. Эдгээр бодисын алинд ч хэрэглээний жор, заавар байх ёсгүйг дурдсан. Энэ ангиллын бодисыг хэрэглэсэн хүн насаараа хоригдох ялтай бөгөөд уг бодисыг хэрэглэн гэмт хэрэг үйлдвэл улам чанга ял, шийтгэл оногдуулжээ.

II-V ангилалд мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын хор хөнөөлийн зэрэг нь их, дунд зэрэг, бага бөгөөд Мансууруулах бодисын хуулийн хэрэгжилтийг хангах газрын эмчийн лицензийн дугаартай жороор олгохыг зөвшөөрсөн бөгөөд V ангилалд орсон зарим бодист заавал жор шаардахгүйг тусгажээ.

Энэхүү хуулиар Марихуана болон Мансууруулах бодисын эсрэг Үндэсний комиссыг (The National Commission on Marijuana and Drug Abuse) байгуулж, марихуанад ноогдуулах ял, шийтгэлийг багасгасан. Тус комиссын анхны дарга Рэймонд П.Шаафер Конгресст тавьсан анхны илтгэлдээ “Одоо үйлчилж буй Эрүүгийн хууль нь мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын хэрэглэгчийг хэрэглээгээ багасгасан тохиолдолд ч хатуу чанга хэвээр үйлчилж буй нь цаг үетэйгээ нийцэхгүй”-г дурдсан байна.

1979 онд Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай хууль гарч 1971 оны НҮБ-ын конвенцид нийцүүлэн бодисын ангиллыг өөрчилсөн байна¹². 1986 онд батлагдсан Мансууруулах бодистой тэмцэх тухай хууль (Anti-Drug Abuse Act) нь эрх зүйн шинэчлэлийг авчирчээ. Хуулийн гол онцлог нь хар тамхины эсрэг тэмцлийг олон арга замаар хийх тухай дурдсан байв¹³. Тухайлбал, АНУ-д мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг импортоор оруулахыг зогсоох тал дээр хамтран ажилладаггүй орнуудаас авдаг бараа бүтээгдэхүүнд импортын татварыг нэмэх эрхийг Ерөнхийлөгчид олгосон бол хуулийн өөр нэг заалт нь мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбогдсон хэрэгтний эд хөрөнгөд (байр, завь, машин, мөнгө зэрэгт) үзлэг хийж болохоор хуульчилжээ. Энэхүү хууль нь анх удаа мөнгө угаах, хууль бус мөнгийг банкны дансанд оруулах, данснаас гаргахын эсрэг эрх зүйн орчинг бий болгосон. 1995 онд Конгрессийн хийсэн судалгаагаар хар тамхинаас олох жилийн ашиг нь 40-80 тэрбум ам.доллараар хэмжигдэж байгаа бөгөөд энэ мөнгийг банкинд байршуулбал худалдагч этгээдийг эрүүгийн хариуцлагад татаж, хууль бус орлого, эд хөрөнгийг хураахаар заажээ.

¹² 1961 онд баталсан НҮБ-ын Мансууруулах эмийн тухай конвенц нь зөвхөн каннабис, коко, опиумын төрлийн бодисыг хориглож байсан бол 1971 онд Австрийн Вена хотод баталсан конвенц нь шинэ төрлийн сэтгэцэд нөлөөлөх бодис болох амфетаминээс, барбитуратес, бензодиазепин болон сикэдеэликс зэргийг оруулсан байна.

¹³ “Anti-drug Abuse Act,” 2013 оны 3 дугаар сарын 7-нд татаж авсан. <http://www.enotes.com/anti-drug-abuse-act-1986-reference/anti-drug-abuse-act-1986>

Хуулийн бас нэг ач холбогдол нь мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис авч яваа этгээдэд заавал хорих ялыг оноон, ялын доод хэмжээг заасан. Хорих ялын хэмжээг хар тамхины хууль бус наймааг зохион байгуулдаг “толгойлогч” эсвэл “дээд түвшний босс”-ууд нь чухам ямар хэмжээний бодис авч яваа байдлаас нь шалтгаалан тогтоосон. Энэхүү хэмжээнд 1000 грамм героин эсвэл 5000 грамм нунтаг кокайныг оруулсан байна. Эдгээр хэмжээний бодисыг санаатайгаар бусдад өгөх зорилгоор биедээ авч яваа бол доод тал нь 10 жилийн хорих ялыг онооно гэжээ. Бага хэмжээний буюу 100 грамм героин эсвэл 500 грамм нунтаг кокайн биедээ авч явсан тохиолдолд “Дунд түвшний” гэж үзэж доод тал нь 5 жил хорих ялаар шийтгэнэ.

Ялын доод хэмжээ

1986 оны хуулийн хамгийн гол ач холбогдол нь нунтаг кокайн болон цэвэр кокайныг биедээ авч яваа этгээдэд оноох ялын доод хэмжээг зааглан ялгаж өгсөн. Цэвэр кокайн авч яваа этгээд “толгойлогч” уу, “дунд түвшний босс” уу гэдгээс үл хамааран, авч яваа цэвэр кокайн нь хэдий хэмжээний нунтаг кокайн болж байгаа хэмжээг 100-д хувааж, ялын доод хэмжээг тодорхойлно гэжээ. Иймээс 5000 гр нунтаг кокайны оронд 50 гр цэвэр кокайн авч явбал 10 жилийн ялтай, 500 гр нунтаг кокайны оронд 5 грамм цэвэр кокайн авч явбал 5 жилийн ялтай. Харин 50 грамм нунтаг кокайныг хууль бусаар борлуулбал заавал ял оноохооргүй заажээ.

1970 оны эхээр эхэлсэн “Хар тамхины эсрэг дайн”-ы бодлого ийнхүү АНУ-д 2012 он хүртэл ямар нэгэн хэмжээгээр өөрчлөгдөн үргэлжилсэн бол 2012 онд шинэ бодлого гаргахаар болсон юм. Энэхүү бодлогын агуулга нь:

- мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисээс үүдэлтэй өвчнийг судалдаг дэлхийн хамгийн шилдэг эрдэмтдийн хийсэн судалгаанд хөрөнгө оруулан, судалгааны үр дүнд тулгуурласан мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хяналтдаа авах

“Гуравдагч арга зам” нэртэй арга барилыг бодлогодоо тусган, хэрэгжүүлэх;

- мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хяналтдаа авахын тулд яаравчилсан түр зуурын хуулийн зохицуулалт хийж, арга хэмжээ авахгүй байх;
- Хэдэн хүнийг баривчилж, хэдэн хорих газрыг байгуулсан тоон үзүүлэлтээр “амжилт”-ыг хэмжихгүй байх зэрэг болно.

Дүгнэн хэлэхэд, АНУ-ын хар тамхи, мансууруулах бодистой холбоотой эрх зүйн орчныг бодисын хор хөнөөл, үйлчлэлийн нөлөөгөөр нь ангилдаг бөгөөд аль ангиллын ямар төрлийн бодисыг хэдий хэмжээгээр авч яваа байдлаар нь ялын бодлогыг тодорхойлдог байна. АНУ-д марихуанад хөнгөн ял оногдуулдаг бол хор хөнөөл ихтэй бодис байгаа тохиолдолд хатуу ял оноож байсан ч 2012 оноос эхлэн зарчмын хувьд цоо шинэ бодлого боловсруулжээ.

3.3 Либерал шинжтэй бодлого явуулдаг орнууд

3.3.1 ХБНГУ-ын эрх зүйн орчин, ялын бодлого

ХБНГУ-ын мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын эрх зүйн орчин нь харьцангуй хөгжсөн бөгөөд Европын бусад улсуудын бодлоготой харьцуулбал хатуу ял, шийтгэл оногдуулдаг байна. 1994 онд ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүх мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хувийн зорилгоор багахан хэмжээгээр авч явах нь гэмт хэрэг биш, мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодист донтсон гэж үзэхгүй гэжээ. 2000 онд батлагдсан Мансууруулах бодисын тухай хуульд аливаа хяналтын дор мансууруулах бодисыг тарилгаар хэрэглэдэг өрөөг¹⁴ бий болгохыг зөвшөөрсөн

¹⁴ Уг өрөө нь ариун цэврийн болон тайван амгалан орчныг бүрдүүлсэн, эмнэлгийн зориулалтын тоног төхөөрөмжөөр тоноглогдсон, олон нийтэд МСНБ –ийг хэрэглэдэг гэж харагдахааргүй байдлаар бэлтгэсэн өрөө байдаг. http://en.wikipedia.org/wiki/Safe_injection_sites.

байна. 2002 онд Германы 7 хотод хийсэн туршилтын судалгаагаар мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодист донтсон хүмүүст геройныг ашигласан эмчилгээ нь метадонд суурилсан эмчилгээнээс илүү үр дүнтэй, хямд төсөр байсан учраас 2009 оноос эхлэн геройнд суурилсан эмчилгээг эрүүл мэндийн даатгалд заавал оруулах үйлчилгээнд хамааруулсан байна.

3.3.2 Голландын эрх зүйн орчин, ялын бодлого

Голландын мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын бодлого нь 2 зарчимд суурилдаг. Нэгдүгээрт, мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын хэрэглээ бол эрүүл мэндийн асуудал бөгөөд эрүүгийн гэмт хэрэг биш гэж үздэг. Хоёрдугаарт, мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг “хатуу” ба “зөөлөн” гэж ангилдаг. Голландад мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистэй холбоотойгоор амь насаа алдсан хүний тоо нь нийт хүн амтай харьцуулахад Европын Холбооны улсууд дотроо хамгийн бага хувьтайд тооцогддог орны нэг юм. Мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын талаар нэгдсэн бодлого байдаг ч марихуанаг хэрэглэхэд ямар нэгэн ял, шийтгэл, хариуцлага хүлээлгэдэггүй ганц орон юм. Мөн, геройнд суурилсан эмчилгээг зөвшөөрсөн анхны улс бөгөөд тусгай зориулалтын өрөөнд уг эмчилгээг хийлгэхийг зөвшөөрсөн байдаг.

“Хөнгөн” гэгдэх мансууруулах бодис, тухайлбал, каннабисын төрлийн бодисыг худалддаг цэгүүд /кофе шоп/ ажилладаг ч 2008 оноос олноор нь хааж эхэлсэн. Ангилалд орсон ямар ч төрлийн мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг импортлох болон экспортлохыг хатуу хориглосон. Хэрэв “хатуу” мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын худалдаанд оролцсон бол 12-16 жилийн хорих ялаар шийтгэгдэх бол их хэмжээний каннабисыг экспортлох болон импортлосон бол дээд тал нь 4 жилийн хорих ял оноодог

байна. Эмчилгээ болон мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодист донтохоос урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь бусад орнуудтай харьцуулахад өндөр. мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистэй тэмцэх хуулийг хэрэгжүүлэхэд бусад Европын орнуудтай харьцуулбал нэг хүнд ногдох мөнгөн дүнгийн хэмжээ нь маш өндөр бөгөөд олон нийтийг мансууруулах бодисоос хамгаалахад зориулсан төсвийн 75 хувийг зөвхөн хуулийг хэрэгжүүлэхэд зарцуулдаг байна.

3.3.3 Португалийн эрх зүйн орчин, ялын бодлого

1999 оны байдлаар Португали нь Европын Холбооны улс дотроо ХДХВ-ийн вирус тээгч тариураар мансуурдаг хэрэглэгчдийн тоогоор хамгийн дээгүүр ордог. Шинээр оношлогдсон ХДХВ-ийн халдвар тээгч хэрэглэгчдийн тоо 2009 он гэхэд 1 сая хүн тутамд 13.4¹⁵ тохиолдлоор багассан ч Европын орнуудын дундаж түвшин болох 1 сая хүн амд 2.85 тохиолдол байх үзүүлэлтээс өндөр хэвээр байна.

ХДХВ-ээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг багасгах зорилгоор эмийн сан, гудамжинд мансууруулах эм, бэлдмэлийн төхөөрөмжийг ажиллуулж, 1 удаагийн тариур тараах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр урьдчилсан сэргийлэх сурталчилгаануудыг байнга хийдэг байна.

Тусгай зөвшөөрөлгүйгээр хувийн зорилгоор мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хэрэглэх, биедээ авч явахыг 2001 онд хуулиар хориглосон. Өмнө нь иймэрхүү хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэж, хорих хүртэл ял оноодог байсан бол тухайн бодис нь 10 өдрийн дотор хэрэглэхээр хэмжээтэй бол захиргааны шийтгэл ноогдуулдаг болжээ.

Донтогсдыг торгож, шийтгэхээс илүү албадан эмчилгээнд оруулах эсвэл хамт олон гэр бүлийн хүрээнд хүмүүжүүлэх

¹⁵ “Drug Policy of Portugal,” 2013 оны 3 дугаар сарын 6-нд татаж авсан. http://en.wikipedia.org/wiki/Drug_policy_of_Portugal

арга хэмжээг заавал авдаг байна. Хэдийгээр эрүүгийн хэрэг үүсгэж, шийтгэл оногдуулаагүй ч мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг биедээ авч явах, хэрэглэх нь хуулиар хориотой. мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг тариалагчид, хууль бусаар худалдах, зуучлан борлуулагчдыг Эрүүгийн хуулиар шийтгэдэг.

Бага хэмжээний бодис авч яваа нь баригдвал шүүхийн зарлан дуудах хуудсын дагуу Португалийн Мансууруулах донтолттой тэмцэх комисст ирж, ярилцлаганд ордог. Комиссын зүгээс хариуцлага тооцох олон арга хэмжээг авдаг. Тухайлбал, 25-150 хүртэл Еврогоор торгох, мэргэжлийн эрхийг түдгэлзүүлэх /хэрэв хэрэглэгч таксины жолооч, хүний эмч бол/, диско клуб зэрэг тодорхой газруудад очихгүй байх, тодорхой зарим хүнтэй уулзахгүй байх, гадаадад аялахыг хориглох, комисстой холбогдон өөрийн талаар илтгэх, галт зэвсэг эзэмшихгүй байх, хувийн эд хөрөнгийг улсын орлого болгох, улсаас авч байгаа тэтгэмж, татаасыг зогсоох зэрэг болно.

Бага хэмжээний буюу борлуулах зорилгогүй эзэмшиж байгаа мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын хэмжээг дараах байдлаар тогтоожээ. Каннабисын ургамал- 25 гр, хашиш- 7.5 гр, каннабисын давирхай жили/тос-2.5 гр, цэвэр ТНС-5 гр, кокаин-2 гр, героин- 1 гр, метадон 1 гр, морфин -2 гр, опиум -10 гр гэх мэт.

3.3.4 ОХУ-ын эрх зүйн орчин, ялын бодлого

ОХУ нь мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг зөвхөн их, онц их хэмжээг зааж, ял оноодог байсан. Жишээлбэл, 5000 грамм героин биедээ авч явсан нь цагдаа, шүүхийн байгууллагаар тогтоогдвол “үлэмж их хэмжээ”-ний бодис гэж тооцогдон хорих ялыг оноодог. ОХУ-ын эрүүгийн хуулийн 228 зүйл ангид¹⁶:

¹⁶ ЦЕГ-ын Эрүүгийн Цагдаагийн газрын Хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх хэлтсээс авсан хуулийн албан бус орчуулга. 2013 оны 4 дүгээр сарын 11. Улаанбаатар.

Мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис болон түүнтэй адилтгах бэлдмэлийг хууль бусаар олж авах, хадгалах, зөөвөрлөх, бэлтгэх, дахин боловсруулах.

1. Худалдан борлуулах зорилгогүйгээр мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг их хэмжээгээр хууль бусаар олж авах, хадгалах, зөөвөрлөх, бэлтгэх, дахин боловсруулсан бол 40,000 /дөчин мянга/ рублээр торгох, эсхүл хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр эсхүл ялтны 3 сарын хугацаанд олсон орлогыг эсхүл 180-240 цаг албадан ажил хийлгэх эсхүл засан хүмүүжүүлэх ажлыг 2 жил хүртлэх хугацаагаар эсхүл 3-н жил хүртлэх хугацаагаар хорих ялаар шийтгэнэ.
2. Дээрх үйлдэл нь онц их хэмжээгээр үйлдэгдвэл 500,000 /таван зуун мянга/ рублээр торгох эсхүл ялтны сүүлийн 3-н жилийн цалин орлогыг хураах болон 3-10 хүртэлх жилээр хорих ялаар шийтгэнэ.

Тайлбар: Энэ зүйл ангид заасан гэмт хэргийг үйлдсэн этгээд нь мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг сайн дураараа гаргаж өгсөн болон хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгаа болон гэмт этгээдийг илчлэх, мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын хууль бус эргэлтээр олсон эд хөрөнгийг илрүүлэхэд, гэмт үйлдлийг таслан зогсооход хууль сахиулах байгууллагатай идэвхитэй хамтран ажилласан бол энэ зүйлд заасан эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөнө.

1. Мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис болон түүнтэй адилтгах бэлдмэлийг гэмт этгээдийг дайчлан баривчилах үед мөн түүнчлэн мөрдөн байцаалтын үйл ажиллагаагаар илрүүлж хураан авсан тохиолдол нь сайн дураараа хэргээ хүлээсэнд тооцогдохгүй.

2. Энэ зүйл болон тус хуулийн 228-1, 229 дугаар зүйлд заасан зорилгоор мансууруулах бодис болон сэтгэцэд

нөлөөлөх эм, бэлдмэл, бодисны их, онц их хэмжээг ОХУ-ын Засгийн газар тогтооно.

3. Мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг их, онц их хэмжээ нь тухайн мансууруулах сэтгэцэд нөлөөт бодис болон түүнтэй адилтгах бэлдмэлийн төрлийн их болон онц их хэмжээтэй ижил байна гэжээ.

2012 оны 3 дугаар сарын 1 -ний өдөр ОХУ-ын Ерөнхийлөгч Эрүүгийн хуулийн 228, 228.1, 229.1 зүйлд нэмэлт өөрчлөлт оруулан баталсан. Хуульд оруулж буй гол өөрчлөлт нь мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг үйлдсэн этгээдэд оногдуулах ялын хэмжээг ялгавартайгаар тогтоож, бодисын хэмжээг тусгаж өгсөн. Тухайлбал, бага хэмжээний бодист хорихоос өөр төрлийн ялыг өгөх болсон. “Энэхүү бодлого нь сэтгэлгээг либералчилсанаараа шинэ хувьсгал” хийж байгаа юм гэж ОХУ-ын Хүний эрхийн комиссын дарга мэдэгджээ. Энэхүү шинэ бодлогын нөлөөгөөр 10 хүртлэх доозын хэмжээгээр хууль бус бодисыг авч явбал торгууль төлнө. Тусгай комиссын тодорхойлсоноор 10 доозын геройн нь 1 грамм геройн болох бөгөөд бодисын хэмжээг илэрхийлсэн шинэ хүснэгтийг гаргасан. Кокаины хэлтэрхийг 1.5 грамм, марихуаныхыг 20 грамм, эсвэл хагас унц гэж тогтоожээ. Энэхүү шинэ бодлого нь дэлхийн нийтийн хандлагатай ойролцоо очиж байгааг хүний эрхийн байгууллагынхан үнэлсэн байна. Мөн, шинэ бодлогын үрээр шоронжсон байдал багасаж, хорих газарт халдварлан тархдаг өвчнийг / сүрьеэ, ДОХ гэх мэт/ багасгана хэмээн донтогсдод эмчилгээ хийдэг мэргэжлийн хүмүүс дурьджээ.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангид оруулсан өөрчлөлт (№18)-ийн дагуу бүх насаар нь хүртэл хорих ялыг онооно. Уг ялыг оноохдоо:

1. ОХУ-ын ЭХ-ийн 228-р зүйлийн 1-5-д: мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг онц их хэмжээтэйгээр бэлтгэх, тараан түгээсэн.

2. ОХУ-ын ЭХ-ийн 229-р зүйлийн 1-д: Хилийн шалганы ажилчидад хүч хэрэглэн мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг онц их хэмжээтэйгээр зохион байгууллалттай бүлгээр хил дамнуулан гаргасан гэжээ. Хуулийг 2013 оноос эхлэн мөрдөнө гэжээ.

3.4 Ялын хатуу бодлоготой орнууд

3.4.1 БНХАУ-ын эрх зүйн орчин, ялын бодлого

БНХАУ нь газар зүйн хэмжээ болон “Алтан гурвалжин”¹⁷-гийн байрлалтай ойрхон байдал, далайн эргийн дагуу байрласан олон томоохон боомтын үр нөлөөгөөр мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын гол дамжуулагч болон хэрэглэгч орон юм. Хятадад опиум нь аль XIX дүгээр зууны дунд үеэс эхэлсэн “Опиумын дайн”-аас ч өмнө өргөн тархсан.

2005 оны эхний байдлаар Хятадад мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хэрэглэгчдийн тоо 35 хувиар өсч, 1.16 саяд¹⁸ хүрсэн гэж цагдаагийн байгууллагаас мэдээлсэн байна. Нийт хэрэглэгчдийн 700 мянга гаруй нь геройнд донтдог бөгөөд эдгээр хүмүүсийн 79 хувь нь 35- аас доош насныхан байгааг онцолжээ¹⁹. Гэвч албан бус тоогоор, донтогсдын тоо 12 саяд хүрсэн бөгөөд 73.9 хувь нь 35-аас доош насных байна гэжээ.²⁰ 2001 оны байдлаар, ХДХВ болон ДОХ-ын халдвар авсан хүмүүсийн нэлээдгүй хэсэг нь геройнд донтдог хэрэглэгчид байна.

2007 онд мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын эсрэг тусгай хууль гарган 2008 оноос

¹⁷ Опиум, геройныг хамгийн ихээр тариалдаг 3 улс болох Бирм, Лаос, Вьетнам орнууд багтдаг.

¹⁸ “China Adopts First Anti-Drug Law,” China Daily, 2013 оны 3 сарын 15-нд татаж авсан. http://www.chinadaily.com.cn/china/2007-12/29/content_6359006.htm

¹⁹ Мөн тэнд

²⁰ “Illegal drug trade in the People's Republic of China,” 2013 оны 4 дүгээр сарын 4-нд татаж авсан. http://en.wikipedia.org/wiki/Illegal_drug_trade_in_the_People%27s_Republic_of_China

хүчин мөрдөж эхэлсэн. Хуульд зааснаар диско, баар, шөнийн клуб зэрэг цэнгээний газруудын эзэд мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хэрэглэж байгаа хүмүүсийг цагдаагийн газарт мэдэгдэх, эс биелүүлбэл шийтгэл хүлээхээр заажээ. Цагдаа нарт шаардлагатай тохиолдолд галт тэрэгний буудал, хот хоорондын автобус болон хил орчмын газар хууль бусаар мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг авч яваа этгээд, түүний ачаа барааг шалгаж, нэгжлэг хийх эрхтэйг заажээ.

Өмнөх хууль, журамд зааснаар мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодист донтогсдыг нөхөн сэргээх төвд эмчилдэг бол шинэ хуулиар 3 жилийн дотор гэр бүл, хамт олны дунд донтолтоос гарах эмчилгээ, арга хэмжээг авч болохыг заасан. Хэрэв донтогсод 16 наснаас доош хүүхэд, жирэмсэн эмэгтэй, 1-ээс доош насны хөхүүл хүүхэдтэй эх байвал тусгаарласан албадан эмчилгээнд хамруулахгүйг заажээ. Эмнэлгийн зориулалтаар хэрэглэх хуулиар хориотой метадон, эфедрин зэрэг мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг нарийн дүрэм, журмын дор хэрэглэхийг зөвшөөрсөн.

Донтсон хэрэглэгчид сайн дураараа эмчлүүлэхээр нөхөн сэргээх төвд очдог ч төлбөрийн чадваргүйн улмаас хамрагдаж чаддаггүй тухай дурьджээ. Албадан эмчилгээнд орсон ч эргээд мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хэрэглэвэл хөдөлмөр хийлгэх замаар “дахин боловсрол” олгодог.²¹

Хятадад мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг их хэмжээгээр хууль бусаар худалдах, зөөвөрлөх зохион байгуулалттай гэмт бүлэглэл, байгууллага харьцангуй бага гэдэг ч мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг том бүлэглэлүүд том усан онгоцоор тээвэрлэхээс илүүтэйгээр бага хэмжээгээр хуваан

²¹ “Illegal drug trade in the People's Republic of China,” 2013 оны 4 дүгээр сарын 4-нд татаж авсан. http://en.wikipedia.org/wiki/Illegal_drug_trade_in_the_People%27s_Republic_of_China

олон газар байрлуулан зөөдөг болохыг албаны эх сурвалж дурьддаг. Хар тамхины наймаачид “Алтан гурвалжин”-аас Хятадын Гуангдунг, бусад мужуудад эмэгтэйчүүд, хүүхэд, ядуу болон боловсролгүй тариачдыг ашиглан мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг биедээ авч яван зөөвөрлүүлэх хэрэг ихээр өссөн. Мьянмараас Хятадын хил хүртлэх усан замаар том хөлөг онгоцууд их үзэгддэг бөгөөд ихэнх нь цагдаа, далайн дээрэм, хулгайгаас сэргийлж автомат буу, гранат зэрэг галт зэвсэгээр зэвсэглэсэн байдаг.

Мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар худалдвал цаазаар авах ял оноодог. БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 7 дугаар бүлгийн 347 дугаар зүйлд²²:

“Мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар хил нэвтрүүлэх, худалдах, тээвэрлэх, үйлдвэрлэсэн этгээдийг 15 жилээр хорих, эсвэл бүх насаар нь хорих эсвэл цаазаар авах ялаар шийтгэж, эд хөрөнгийг улсын орлого болгоно:

1. 1000 граммаас бага хэмжээний опиум, 50 граммаас бага хэмжээний героин, метилийн бензэдрин болон бусад мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг их хэмжээгээр хууль бусаар хил нэвтрүүлэх, худалдах, тээвэрлэх эсвэл үйлдвэрлэхэд
2. мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар хил нэвтрүүлэх, худалдах, тээвэрлэх эсвэл үйлдвэрлэхэд оролцсон гэмт бүлэглэлийг удирдахад
3. мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар хил нэвтрүүлэх, худалдах, тээвэрлэх эсвэл үйлдвэрлэхээр галт зэвсэг ашиглан хамгаалалт хэрэглэсэн бол

²² “On the Death penalty for Drug-Related Crime in China,” Human Rights and Drugs, vol. 2, No1. 2013 оны 4 дүгээр сарын 15-нт татаж авсан. <http://www.humanrightsanddrugs.org/wp-content/uploads/2012/05/IJHRDP-vol-2-2012-BI.pdf>

4. Шалгалт, нэгжлэг хийх, илрүүлэх, баривчлах үед хүч хэрэглэн эсэргүүцэл үзүүлбэл
5. Зохион байгуулалттай олон улсын хар тамхины хууль бус худалдаанд оролцсон болгож заажээ.

Иймээс 50 граммаас дээш геройн авч яваа нь илэрвэл цаазаар авах ял оноодог байна.

Хүний эрхийн зарим байгууллагаас Хятадын цаазаар авах ялын бодлогод шүүмжлэлттэй ханддаг. Тухайлбал, практикаас харахад ялын дээд хэмжээг оноохдоо зөвхөн хэдий хэмжээний бодис вэ гэдэг тоон үзүүлэлтээр л хэмжиж байгаагаас биш тухайн бодис цэвэр найрлагатай эсэх, учруулах хор хөнөөлийн агууламжийг харгалзан үздэггүй. Энэ талаар ч хуульдаа баталгаажуулан заасан байдаг. Түүнчлэн, хуульд зааснаар мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар хил нэвтрүүлэх, худалдах, тээвэрлэх эсвэл үйлдвэрлэх хууль бус үйлдлийг давтан үйлдсэн бол мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын хэмжээг өмнө авч явсан хэмжээтэй нь нэмж тооцон, ялыг хүндрүүлэн зүйлчилнэ гэжээ. Энэ нь бага хэмжээний бодисыг авч яваа хүнд ч цаазын ял оноох боломжийг шууд өгч байна.

3.4.2 Зүүн өмнөд Азийн бусад орнуудын ялын бодлого

Зүүн өмнөд Ази нь хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх ялын хамгийн хатуу бодлотой бүс нутагт тооцогддог.

Тайланд болон Вьетнам улсуудад зүү солих үйл ажиллагаа нь хуулиар хориотой. Гэвч далд, нууц байдлаар энэхүү үйл ажиллагааг зохион байгуулдаг байна. Лаос болон Мьянмарт мөн л зүү, тариурын талаарх зүйлс хуулиар хориотой байдаг ч Мьянмарт одоогийн байдлаар 24 газар зүү солих хөтөлбөр тогтмол үйл ажилгаагаа явуулж байна.

Зүүн-Өмнөд Ази нь хар тамхи хэрэглэгчийг цээрлүүлэх хатуу бодлогоороо дэлхийд тэргүүлэгч бус нутаг тул

мансууруулах бодис, хар тамхины асуудлаар ял эдэлж буй хоригдлын тоо маш их юм. Түүнчлэн оногдуулаж байгаа ял нь үйлдсэн гэмт үйлдэлтэй нь харьцуулахад хэт чанга байдаг.

Вьетнам, Малайз, Сингапур улсуудад хар тамхи тээвэрлэсэн тохиолдолд цаазаар авах ял оногдуулдаг ба зөвхөн Тайланд улсад гэхэд 2003 онд 2300 хүнийг 3 сарын дотор цаазаар авсан байх жишээтэй.

Зүүн-Өмнөд Азийн хар тамхитай холбоотой ялын бодлогыг тоймловол:

1. Камбож: хар тамхитай холбоотой үйлдэлд цаазаар авах ялыг халсан хэдий ч 5 жилийн хорих ял оноож байна.
2. Индонез: хар тамхи тээвэрлэсэн тохиолдолд цаазаар авах ял оногдуулдаг, мөн энэ нь марихуан бол 20 хүртэл жилийн ял ногдуулдаг. Хар тамхи хадгалсан тохиолдолд 4-20 жилийн ял ногдуулдаг.
3. Лаос: 100 грам героин хадгалсан бол 10 жилийн хорих ялаар шийтгэж, 35.000 ам.долларын торгууль ногдуулдаг.
4. Малайз: хар тамхи тээвэрлэсэн тохиолдолд цаазаар авах ял шийтгэдэг.
5. Филиппин: тээвэрлэгч нь 0.3 унци опиум, морфин, героин, кокаин, марихуанын давирхай, 17 унцаас дээш марихуанатай баригдвал цаазаар авах ял шийтгэдэг. Одоогоор тус улсад цаазаар авах ялыг түдгэлзүүлсэн байгаа ч доод тал нь 12 жилийн хорих ялаар шийтгэнэ.
6. Сингапур: хэрэв 0.5 унци героин, 1 унци морфин, эсхүл кокаин, 17 унцаас дээш хэмжээгээр марихуана агуулж яваад баригдвал хар тамхи тээвэрлэгч гэж тооцогдох ба цаазаар авах ял шийтгэдэг. 1991-2004 оны хооронд энэ хэрэгт нийт 400 хүн цаазаар авах ялаар шийтгүүлсэн.

7. Тайланд: героиныг хэрэглэх зорилготой авсан бол цаазаар авах ял шийтгэнэ.
8. Вьетнам: 1,3 паунд ба түүнээс дээш хэмжээний героинтой баригдвал цаазаар авах ял шийтгэдэг. Зөвхөн 2007 онд 85 хүн энэ гэмт хэргийн улмаас цаазаар авахуулсан.

ДӨРӨВ. МОНГОЛ УЛСАД МАНСУУРУУЛАХ БОДИС БОЛОН СЭТГЭЦЭД НӨЛӨӨЛӨХ ЭМ, БЭЛДМЭЛ, БОДИСТОЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ШҮҮХИЙН БОЛОН ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭНИЙ ПРАКТИК

4.1 Монгол Улсын мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой эрх зүйн зохицуулалт, ялын бодлого

Монгол Улсад мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой 10 гаруй хууль тогтоомж үйлчилж байна. Эдгээрийг тоймловол:

1. Хар тамхи, мансууралтай тэмцэх үндэсний хөтөлбөр /2000 онд батлагдаж, 2005 онд хэрэгжиж дууссан/.
2. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралтын 3.4.4 дэх бүлгийн “Иргэдийг үндэстэн дамнасан гэмт хэргээс хамгаалах” бодлого
3. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /2002 он/
4. Эрүүгийн хуулийн 188 /Нийгмийн аюулгүй байдал, хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг гэсэн бүлэгт “Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, хар тамхи, мансууруулах буюу хордуулах, цацраг идэвхит, тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар Монгол Улсын

хил нэвтрүүлэх”/, 192-196 дугаар зүйл буюу Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн бүлэг, Эрүүгийн хуулийн 115 буюу хүүхдийг согтуурал, мансууралд татан оруулах

5. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гэр бүлийн тухай хууль
6. 1998-2003 онд баталсан УИХ-ын тогтоол №5, Монгол Улсын Засгийн газрын тогтоол №52, 54, 138, 196, Эрүүл мэндийн Сайдын тушаал №306, Гаалийн Ерөнхий газрын даргын тушаал №348 зэрэг болно.
7. Монгол Улс 1961 оны Мансууруулах эмийн тухай конвенцид 1990 онд, 1971 оны Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенцид 1999 онд, 1988 оны Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенцид 2001 онд, 2000 оны Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцид 2008 онд тус тус нэгдэн орсон.

1961 оны Эрүүгийн хуульд мансууруулах бодисын хууль бус эргэлтийг гэмт хэрэгт тооцож ялтай болгосон билээ.²³ Одоогоор үйлчилж байгаа Эрүүгийн хуулийн 188, 192-196 зүйлүүдэд заасан мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан, тээвэрлэсэн, зарж борлуулсан, улсын хил хууль бусаар нэвтрүүлсэн үйлдлийг гэмт хэрэгт тооцож ял оногдуулж байна. Борлуулах зорилгогүйгээр мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан бол торгох, баривчлах, эсхүл 2 жил хүртэл хугацаагаар хорих бол борлуулах зорилгоор мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэсэн,

²³ “Хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн ялын бодлого” сэдэвт хэлэлцүүлгийн эмхтгэл, Монгол Улсын шүүхээс мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, бэлдмэл бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн байдал, анхаарах зарим асуудал, Ч.Нямсүрэн, (Улаанбаатар, 2012), 21.

олж авсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, борлуулсан бол таваас дээш найман /5-8/ жил хүртэл хугацаагаар хорих, хэрэв энэ гэмт хэргийг:

- Онц их хэмжээгээр²⁴
- Насанд хүрээгүй хүн оролцуулж,
- Онц аюултай гэмт хэрэгтэн
- Давтан
- Урьдчилж үгсэж тохиролцсон буюу зохион байгуулалттай бүлэг гэмт бүлэглэл үйлдсэн бол арваас дээш арван таван жил /10-15/ жил²⁵ хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Эрүүгийн хуулийн ззохицуулалтыг харьцуулж үзээд ял шийтгэлийн бодлогод дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын зорилгыг хуульд тодотгож өгсөн байна. /Өөрөөр хэлбэл, борлуулах уу, эсвэл борлуулах зорилгогүй юу? гэдгийг ялгах боломжтой/
2. Мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын хэрэглэсэн үйлдэлд ял, шийтгэл хүлээлгэх талаар заалт байхгүй.²⁶
3. Мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын хэмжээг тодорхой нарийн зааж өгөөгүй байна. Зөвхөн онц их хэмжээ гэдэг байдлаар дурдсан боловч, нарийн хэмжээг тодорхойлоогүй.
4. Мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын төрөл, хор хөнөөлийн агууламж, нөлөөллийн зэрэглэлийг тогтоогоогүй байна.

²⁴ Онц их хэмжээг хэдий хэмжээний бодис гэдгийг нарийн зааж өгөөгүй. Дээд шүүхийн тайлбар байхгүй.

²⁵ “Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Улсын Дээд шүүхийн тогтоол,” 2009, 70.

²⁶ М.Хоролсүрэн, Д.Баясгалан, Цагдаагийн Мэргэжлийн Сургалт 4-р дэвтэр, (Улаанбаатар:2005), 77.

5. Мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын гарал үүслээр нь байгалийн цэвэр байдлаар уу, нийлэгжүүлсэн, хагас нийлэгжүүлсэн эсэх талаар ангилал байхгүй байна.
6. Мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой хэрэгт хүүхдийг оролцуулсан, онц аюултай хэрэгтэн болон гэмт бүлэглэл үйлдсэн, давтан, онц их хэмжээгээр хийсэн бол ял, шийтгэлийг хүндрүүлж байна.
7. 188 дугаар зүйлд “хар тамхи” гэсэн хууль зүйн бус нэр томъёо хэрэглэсэн нь оновчтой бус²⁷, олон улсын конвенцийн нэр томъёотой зөрчилдөж байна.

2012 оны 03 дугаар сарын 01-ний өдөр Төрийн ордны Иргэний танхимд “Хар тамхи, мансууруулах бодисын өнөөгийн нөхцөл байдал” сэдэвт хэлэлцүүлгийн үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч хар тамхитай холбоотой асуудалд хатуу бодлого барьж, хууль дүрмийг чангатгана гэдгээ илэрхийлжээ.

Мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын хэрэглэгчдийн тоо, хууль бус эргэлтийн хэмжээгээр дэлхийд дээгүүр ордог хоёр хөрштэй, цөөн хүн амтай, хүн амын ихэнх нь хүүхэд, залуус байгаа манай орны нөхцөлд мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын эсрэг хатуу чанга бодлого баримтлах нь зөв гэдэгтэй санал нэг байна. Учир нь хөрш хоёр орны хувьд тухайлбал, Хятад нь маш хатуу ялын бодлоготой тул зэрэгцээ оршин байгаа Монгол Улс зөөлөн, аядуу ялын шийтгэлтэй бол идэвхтэй “дамжуулагч” улс болох магадлал өндөр юм. Хэрэв ийм орон болвол нийт дамжин өнгөрч байгаа мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл,

²⁷ “Хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн ялын бодлого” сэдэвт хэлэлцүүлгийн эмхтгэл, Монгол Улсын шүүхээс мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, бэлдмэл бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн байдал, анхаарах зарим асуудал, Ч.Нямсүрэн, (Улаанбаатар, 2012), 21.

бодисын 20 орчим хувь нь²⁸ тухайн орондоо үлддэг гэсэн судалгаа байдаг ажээ. Иймэрхүү нөхцөл байдал нь Монгол орны үндэсний аюулгүй байдал, хүн амын эрүүл мэнд, удмын санд хор хөнөөлтэй нь ойлгомжтой.

Бага хэмжээгээр мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг авч яваа хүнд хэт зөөлөн ял оноох нь мөн зохимжгүй юм. Учир нь бага хэмжээгээр авч явж болох нь зүгээр гэсэн ойлголт бий болж, хэрэглээ, хууль бус эргэлтийг дэмжих бодлого юм.

Нөгөө талаар, мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хэдий хэмжээгээр ямар зорилгоор эзэмшиж байгаагаас шалтгаалан ял, шийтгэлийг ялгавартай оногдуулах нь шударга ёсонд нийцнэ хэмээн үзэж байна. Түүнчлэн, хувийн хэрэгцээнд бага хэмжээгээр эсхүл нэг удаагийн хэрэглэх хэмжээгээр мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг авч яваа нь илэрвэл ялын хатуу бодлого зохимжгүй хэмээн үзэж байна. мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодист донтсон бол “өвчтөн” хэмээн үзэж, хатуу ял шийтгэлээс илүүтэйгээр эмчилгээ, нийгэмшүүлэх арга хэмжээ авах нь дэлхий нийтийн хандлага болж байна.

4.2 1986 оноос хойшхи шүүхийн тогтоол, шийдвэрт хийсэн судалгаа

Мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөт эм, бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэргийг Монгол Улсын 1986 болон 2002 оны Эрүүгийн хуулиар хянан шийдвэрлэсэн шүүхийн практикийг судалж, цаашид хууль хэрэглээний нэгдсэн зөв практик тогтоох, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар санал боловсруулахад судалгааны зорилгыг чиглүүллээ.

Мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэргийг 1986 оны

²⁸ ЦЕГ-ын Хар тамхи, мансууруулах бодисын асуудал хариуцаж байсан ажилтантай хийсэн ярилцлагаас. 2013 оны 4 сарын 18.

Эрүүгийн хуулийн 254 дүгээр зүйлд “Мансууруулах бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах”, 255 дугаар зүйлд “Тариалахыг хориглосон мансууруулах бодис бүхий ургамал тарих, ургуулах”, 2002 оны Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйлд “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах”, 193 дугаар зүйлд “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг үйлдвэрлэх, бэлтгэх журам зөрчих”, 194 дүгээр зүйлд “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар авах”, 195 дугаар зүйлд “Мансууруулах бодис агуулсан ургамлыг тарих, ургуулах, хурааж авах”, 196 дугаар зүйлд “Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх бодисыг хэрэглэх газар зохион байгуулах”, 188 дугаар зүйлд заасан “Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, хар тамхи, мансууруулах буюу хордуулах, цацраг идэвхт, тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлэх” гэж тус тус зүйлчилсэн байна.

Эрүүгийн хуулийн 188 дугаар зүйлд заасан “Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, хар тамхи, мансууруулах буюу хордуулах, цацраг идэвхт, тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлэх” гэмт хэрэг нь Эрүүгийн хуулийн 21 дүгээр бүлэгт заасан “Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэсэн бүлэг”-т хамаарч байхад Эрүүгийн хуулийн 192-196 дугаар зүйлд заасан гэмт хэргүүд нь Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан “Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг” бүлэгт хамаарч байна.

1986 оны Эрүүгийн хуулийн 254 дүгээр зүйлд заасан “Мансууруулах бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах”, мөн 255 дугаар зүйлд заасан “Тариалахыг хориглосон мансууруулах бодис бүхий ургамал тарих, ургуулах” гэсэн зүйлийг 2002 оны Эрүүгийн хуулийн 192 болон 195 дугаар зүйлд өөрчлөн найруулснаас гадна Эрүүгийн хуулийн 188, 193, 194, 196 дугаар зүйлийг шинээр Эрүүгийн хуульд хуульчилж, Эрүүгийн хуульд нэмэлт

өөрчлөлт оруулах тухай 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар Эрүүгийн хуулийн 188, 193, 196 дугаар зүйлд нэмэлт өөрчлөлт оруулжээ.

Мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис нь хүн амын эрүүл мэндийг богино хугацаанд, өргөн хүрээнд хамран сарниулах, улмаар хүний удмын санд нөлөөлөх, бие махбодийн болоод сэтгэл зүйн хараат байдал үүсгэх нь энэ төрлийн гэмт хэргийн хор аюулыг илтгэх бөгөөд тухайн гэмт хэргийн объект нь нийгмийн аюулгүй байдал, хүн амын эрүүл мэндийн эсрэг чиглэгдсэн байдаг. Харин объектив талын хувьд мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар олж авсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, борлуулсан идэвхтэй үйлдлээр төгсдөг, хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг юм.

Хүснэгт 1

Мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой зарим гэмт хэргийн талаарх 1986, 2002 оны Эрүүгийн хуулийн зохицуулалт, тэдгээрийг харьцуулсан байдал

<p>254 дүгээр зүйл. Мансууруулах бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах</p> <p>1. Мансууруулах бодисыг борлуулах зорилгоор хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, борлуулсан бол найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. /1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар зарим ялыг хассан./</p> <p>2. Энэ үйлдлийг зохин байгуулалттай бүлэг этгээд, онц аюултай гэмт хэрэгтэн, эсхүл энэ хуулийн 253 дугаар зүйлд заасан хэргийг урьд үйлдсэн этгээд хийсэн, эсхүл их хэмжээтэй буюу давтан үйлдсэн, түүнчлэн мансууруулах бодисыг хүүхэд худалдсан, эсхүл тэднээр худалдуулсан, энэ үйлдэлд бусад хэлбэрээр хүүхдийг оролцуулсан бол арваас хорин таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>	<p>192 дугаар зүйл. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах</p> <p>192.1. Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг борлуулах зорилгогүйгээр хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зугаас нэг зуунтавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>192.2. Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг борлуулах зорилгоор хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, борлуулсан бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>	<p>Нэмэлдсэн: Энэ гэмт хэргийн объектод сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг. 254-р зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт торгох ялыг, Баривчлах ялыг, Урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэнийг хүндрүүлэх нөхцөл байдалд тооцохыг, Өөрчлөлдсөн: 254-р зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг 192.2-р зүйлд, 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг 192.3-р зүйлд, 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийг 192.1-р зүйлд тус тус хуульчилсан, 254-р зүйлийн 1 дэх хэсгийн ... найман жил хүртэл хугацаагаар хорих гэснийг 192.2-р зүйлд ... таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих гэж, 254-р зүйлийн 3 дахь хэсгийн ... гурван жил хүртэл хугацаагаар хорих гэснийг 192.1-р зүйлд ... хоёр жил хүртэл хугацаагаар хорих гэж, 254-р зүйлийн 2 дахь хэсгийн ... хүүхдээр худалдуулсан, энэ үйлдэлд бусад хэлбэрээр хүүхдийг оролцуулсан гэснийг 192.3.2-р зүйлд насанд хүрээгүй хүн оролцуулж гэж.</p>
--	---	---

<p>3. Мансууруулах бодисыг борлуулах зорилгогүйгээр хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, түүнчлэн эдгээр бодисыг үйлдвэрлэх, олж авах, тавьж олгох, хадгалах, бүртгэх, тээвэрлэх, илгээх талаар тогтоосон журам зөрчсөн бол гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгэнэ.</p>	<p>192.3.Энэ хуулийн 192.2-т заасан хэргийг: 192.3.1. онц их хэмжээгээр; 192.3.2. насанд хүрээгүй хүн оролцуулж; 192.3.3 онц аюултай гэмт хэрэгтэн; 192.3.4. давтан; 192.3.5. урьдчилан үгсэж тохиролцсон буюу зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>	<p>Хасагдсан: Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг, Хүчтэй үйлчлэх болон хорт бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах гэмт хэргийг урьд хийсэн этгээд үйлдсэн, мансууруулах бодисыг хүүхдэд худалдсаныг хүндрүүлэх нөхцөл байдалд тооцохыг, 254-р зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийн Мансууруулах бодисыг борлуулах зорилгогүйгээр хууль бусаар тээвэрлэсэн, илгээсэн, түүнчлэн эдгээр бодисыг үйлдвэрлэх, олж авах, тавьж олгох, хадгалах, бүртгэх, тээвэрлэх, илгээх талаар тогтоосон журам зөрчсөнийг, ,</p>
<p>255 дугаар зүйл. Тариалахыг хориглосон мансууруулах бодис бүхий ургамал тарих, ургуулах Хар тамхи, энэтхэгийн опсны болон тариалахыг хориглосон мансууруулах бодис бүхий бусад ургамлыг тарьсан, ургуулсан бол гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгэнэ.</p>	<p>195 дугаар зүйл. Мансууруулах бодис агуулсан ургамлыг тарих, ургуулах, хурааж авах 195.1. Мансууруулах бодис агуулсан ургамлыг тарьсан, ургуулсан, хурааж авсан бол хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>	<p>Өөрчлөгдсөн: Тариалахыг хориглосон мансууруулах бодис бүхий ургамал гэснийг мансууруулах бодис агуулсан ургамал гэж, ... гурван жил хүртэл хугацаагаар хорих гэснийг ... хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих гэж, Хасагдсан: Энэ гэмт хэргийн объектоос хар тамхи, энэтхэгийн олсны ургамлыг хасаж ерөнхийд нь томьёолсон, Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг, Нэмэгдсэн: Мансууруулах бодис агуулсан ургамлыг хурааж авахыг гэмт хэрэгт тооцохыг,</p>



1993 оны Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар мөн хуулийн 254 дүгээр зүйлийн 1-д заасан гэмт хэрэг нь хүнд, 2-д заасан гэмт хэрэг нь онц хүнд, 3-т заасан гэмт хэрэг нь хүндэвтэр, 2002 оны Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлд зааснаар мөн хуулийн 192 дугаар зүйлийн 192.1-д заасан гэмт хэрэг нь хүндэвтэр, 192.2-т заасан гэмт хэрэг нь хүнд, 192.3-т заасан гэмт хэрэг нь онц хүнд, 188 дугаар зүйлийн 188.2-т заасан гэмт хэрэг нь хүнд, 188.3, 188.4-т заасан гэмт хэрэг нь онц хүнд гэмт хэргийн ангилалд хамаарч байна.

Монгол Улсын хэмжээнд 1986-2012 оныг хүртэлх хугацаанд Эрүүгийн хуулийн дээрх зүйл хэсгүүдэд заасан гэмт хэрэгт нийт 158 хүнд холбогдох 79 хэргийг хянан шийдвэрлэснээс 18 хувь буюу 14 хүнд холбогдох 6 хэрэг 2002 оны Эрүүгийн хуулийн 188 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт давхар зүйлчлэгдсэн, 94,2 хувь буюу 151 хүнд холбогдох 66 хэргийг 1986 оны Эрүүгийн хуулийн 254, 2002 оны Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйлд заасан гэмт хэргүүд эзэлж байна.

Мөн 92,8 хувь буюу 142 хүнд холбогдох 65 хэргийг Нийслэл, дүүргийн шүүхүүд хянан шийдвэрлэжээ.

Хүснэгт 2

Нийслэл, дүүргийн шүүхээр хянан шийдвэрлэсэн мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой хэргийн судалгаа /1986-2013 он/

Д/д	Он	зүйл анги	Үүнээс															
			Нийслэлд		Нийслэлийн шүүх		Баянзүрх дүүрэг		Баянгол дүүрэг		Чингэлтэй дүүрэг		Сүхбаатар дүүрэг		Хан-Уул дүүрэг		Сонгинохайрхан дүүрэг	
			хэрэг	хүн	хэрэг	хүн	хэрэг	хүн	хэрэг	хүн	хэрэг	хүн	хэрэг	хүн	хэрэг	хүн	хэрэг	хүн
1	1990	254																
2	1991	254																
3	1992	254																
4	1993	254	2	2	1	1				1	1							
5	1994	254																
6	1995	254	2	8	1	7	1	1										
7	1996	254	1	2			1	2										
8	1997	254																
9	1998	254	6	18	3	14						3	4					
10	1999	254	3	5			1	1	1	1		1	3					
11	2000	254	4	16	2	10					1	3	1	3				
12	2001	254	1	1								1	1					
13	2002	254																
14	2003	192	1	1			1	1										
		254	1	2			1	2										
15	2004	192	2	2						2	2							
16	2005	192	1	3			1	3										
17	2006	192																

18	2007	192	2	14				11			1	1	1	2				
		188	1	2			1	2										
19	2008	192	3	11							2	2	1	9				
20	2009	192	6	11			2	4			1	2	2	4			1	1
21	2010	192	2	3			1	2	1	1								
		188	2	2							1	1			1	1		
22	2011	192	11	19			6	14	1	1	2	2	1	1			1	1
		188	1	1							1	1						
23	2012	192	11	17			2	4	2	3	2	3	1	1	3	5	1	1
24	2013	192	2	2					1	1		1	1					
		188	2	9			1	7							1	2		
25	БҮГД	67	151	7	32	18	54	6	7	14	19	13	28	4	8	3	3	

Улсын Дээд шүүхийн судалгааны төв болон Нийслэл дүүргийн шүүхийн эрүүгийн хэргийн нэгдсэн мэдээнээс харахад 1986 оны Эрүүгийн хуулийн 255 дугаар зүйл, 2002 оны Эрүүгийн хуулийн 193 дугаар зүйлд заасан “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг үйлдвэрлэх, бэлтгэх журам зөрчих”, 194 дүгээр зүйлд заасан “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар авах”, 195 дугаар зүйлд заасан “Мансууруулах бодис агуулсан ургамлыг тарих, ургуулах, хурааж авах”, 196 дугаар зүйлд заасан “Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх бодисыг хэрэглэх газар зохион байгуулах” гэмт хэрэгт шүүхээр ял шийтгүүлсэн тохиолдол одоогоор бүртгэгдээгүй байна.

Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх Эрүүгийн хэргийн архивт орон нутгийн шүүхээр хянан шийдвэрлэгдсэн зөвхөн онц хүнд ангиллын гэмт хэргүүд хадгалагддаг бөгөөд хөнгөн, хүндэвтэр, хүнд ангиллын хэргүүд нь аймгийн Прокурорын дэргэдэх архивт хадгалагддаг тул дэлгэрэнгүй судалгааг Эрүүгийн хэргийн төв архивт хадгалагдаж байгаа Нийслэл, дүүргийн шүүхээр хянан шийдвэрлэгдсэн хэргийн

материалд тулгуурлан гаргасан болно.

4.2.1 1986 оны Эрүүгийн хуулиар хянан шийдвэрлэсэн мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөт эм, бэлдмэл, бодистой холбоотой хэргийн судалгаа

1986 оны Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэг “Нийгмийн аюулгүй байдал, нийгмийн хэв журам хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг”-т хамаарах 254 дүгээр зүйлд **Мансууруулах бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах.**

1. Мансууруулах бодисыг борлуулах зорилгоор хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, борлуулсан бол *эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр* найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ үйлдлийг зохион байгуулалттай бүлэг этгээд, онц аюултай гэмт хэрэгтэн, эсхүл энэ хуулийн 253 дугаар зүйлд заасан гэмт хэргийг урьд үйлдсэн этгээд хийсэн, эсхүл их хэмжээтэй буюу давтан үйлдсэн, түүнчлэн мансууруулах бодисыг хүүхдэд худалдсан, эсхүл тэднээр худалдуулсан, энэ үйлдэлд бусад хэлбэрээр хүүхдийг оролцуулсан бол арваас хорин таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3. Мансууруулах бодисыг борлуулах зорилгогүйгээр хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, түүнчлэн эдгээр бодисыг үйлдвэрлэх, олж авах, тавьж олгох, хадгалах, бүртгэх, тээвэрлэх, илгээх талаар тогтоосон журам зөрчсөн бол гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгэнэ гэж заасан байсныг 1993 оны Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар 254 дүгээр зүйлийн 1-д заасан эд хөрөнгө хураах буюу хураахгүй байх нэмэгдэл ялыг хассан байна.

Хүснэгт 3


1986 оны Эрүүгийн хуульд 1993 оны Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар оруулсан өөрчлөлт

БНМАУ-ын Эрүүгийн хууль /1986 он/	1993 оны Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль	Өөрчлөлт
<p>254 дүгээр зүйл. Мансууруулах бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах. 1. Мансууруулах бодисыг борлуулах зорилгоор хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, борлуулсан бол <i>эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр</i> найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>	<p>254 дүгээр зүйл. Мансууруулах бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах. 1. Мансууруулах бодисыг борлуулах зорилгоор хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, борлуулсан бол найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>	<p>Эд хөрөнгө хураах нэмэгдэл ялыг хассан</p>

1986-2001 онд Нийслэл, дүүргийн шүүхээр 1986 оны Эрүүгийн хуулийн 255 дугаар зүйлд заасан гэмт хэрэг шийдвэрлэсэн тохиолдол бүртгэгдээгүй, харин 254 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт 52 хүнд холбогдох 19 хэргийг хянан шийдвэрлэжээ. Судалгааны хүрээнд дээрх 52 хүнд холбогдох таслан шийдвэрлэх тогтоол болон УЕПГ-ын дэргэдэх Эрүүгийн хэргийн төв архивт хадгалагдаж буй 8 хэргийг уншиж судалсан бөгөөд үлдэх 11 хэрэг нь архивын хадгалалтын хугацаа дуусаж устгагдсан байсан.

График 1

1986 оны Эрүүгийн хуулийн 254 дүгээр зүйлээр шийдвэрлэгдсэн хэргийн судалгаа



- Эдгээр хэргийн дотроос 9 хүн нь Эрүүгийн хуулийн өөр зүйл хэсэгт заасан гэмт хэрэгт давхар ял шийтгүүлсэн байна. Үүнд:

- Эрүүгийн хуулийн 74 дүгээр зүйлийн 1, 2-т заасан гэмт хэрэгт 4 хүн,
- Эрүүгийн хуулийн 79 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт 1 хүн,
- Эрүүгийн хуулийн 225 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт 1 хүн,
- Эрүүгийн хуулийн 127, 124, 123, 126 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт 2 хүн,
- Эрүүгийн хуулийн 292 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт 1 хүн тус тус давхар ял шийтгэгджээ.

ОИХ.МН
СУДАЛГААНЫ САН

Хүснэгт 4

1986-2001 онд нийслэл, дүүргийн шүүхээр хянан шийдвэрлэсэн хэргийн судалгаа


Шийдвэрлэсэн он	1986-2001			НИЙТ
	254-1	254-2	254-3	
Зүйл анги	254-1	254-2	254-3	
Хэрэг	7	2	10	19
Хүн	30	2	20	52
Эрүүгийн хуулийн өөр зүйлд заасан гэмт хэрэгт давхар ял шийтгэгдсэн	4	-	5	
Ял шийтгүүлсэн хүн	30	2	20	52

- Ял шийтгэгдсэн 52 хүнээс 15 нь уг мансууруулах бодисыг өөртөө хэрэглэдэг, үүнээс 5 хүн нь идэвхтэй хэрэглэдэг бол 10 хүн нь тохиолдлын журмаар анх удаа хэрэглэсэн гэж мэдүүлсэн байна.

Идэвхтэй хэрэглэдэг 2 хүн нь мансууруулах бодисыг олж авахын тулд бусдын эд хөрөнгийг хулгайлах, залилах, дээрэмдэх зэрэг гэмт хэрэг үйлдэн Эрүүгийн хуулийн өөр зүйл хэсэгт зааснаар давхар ял шийтгүүлсэн

График 2

Мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан шалтгаан /1986-2001 он/



Мөн эмэгтэй хүн 11, насны ангиллаар авч үзвэл 17-18 насны хүн 1, 19-36 насны хүн 28, 36-аас дээш насны хүн 23 байна.

Хүснэгт 5


Мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэргийн ялтны судалгаа /1986-2001 он/

Зүйл анги	Ял шийтгүүлсэн хүн	Хүйс /эм/	Урьд ял шийтгүүлсэн эсэх	Гадаадын иргэн	Нас			Боловсрол				Эрхэлдэг ажил			
					16-18	19-36	36-аас дээш	Дээд	Дунд	Бага	Боловсролгүй	Оюутан, Сурагч	Ажилтай	Ажилгүй	Бусад
254-1	30	7	4		14	16	14	15		1		4	22	4	
254-2	2		1	1	2			2			1		1		
254-3	20	4	2	3	1	13	6	5	14		1	5	2	6	7

Шүүхээс ял оногдуулсан байдлыг судалж үзэхэд торгох ялаар 17 хүн, хорих ялаар 35 хүн ял шийтгүүлсэн, үүнээс 1 жил хүртэл хорих ялаар 12 хүн, 1-3 жил хорих ялаар 19 хүн, 4-5 жил хорих ялаар 2 хүн, 5-10 жил хүртэл хорих ялаар 2 хүн ял шийтгүүлсэн бөгөөд шүүхээс оногдуулсан хорих ялыг тэнсэж хянан харгалзсан 21, тогтоол биелүүлэхийг хойшлуулсан 1, өршөөлд хамруулсан 5 хүн, үлдсэн 8 хүний хорих ялыг биечлэн эдлүүлэхээр тогтоожээ.

График 3

Ял шийтгэлийн судалгаа /1986-2001 он/



Хорих ялыг биечлэн эдлүүлсэн 8 хүний хувьд, 6 хүн нь Эрүүгийн хуулийн өөр зүйлд заасан гэмт хэрэгт давхар ял шийтгэгдсэн, 1 хүн онц хүнд гэмт хэрэгт ял шийтгэгдсэн бол 1 хүн тэнсэн хянан харгалзсан хугацаанд дахин гэмт хэрэг үйлдсэний улмаас хорих ялыг биечлэн эдлүүлэхээр шийдвэрлэжээ.

Мансууруулах бодистой холбоотой хэргийг хянан шийдвэрлэсэн шийтгэх тогтоолуудыг судалж үзэхэд хар тамхи, мансууруулах үйлчилгээ бүхий каннабис /Тетра гидро каннабинол/ бодис агуулсан хагас боловсруулсан бэлдмэлийг хэрэглэх, бусдад борлуулах зорилгоор БНХАУ-аас худалдан авч, Монгол Улсад оруулж ирсэн гэж мэдүүлсэн 3, Тува улсаас оруулж ирсэн гэж 1, Япон улс болон ОХУ-ын Буриадаас ирсэн хүнээс худалдан авсан гэж 2 хүн мэдүүлсэн байна. Харин бусад шүүгдэгч нар нь мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг Монгол Улсын нутаг дэвсгэр дээрээс олж авсан, тухайлбал, Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон аймгийн нутгаар ургадаг Каннабисийн төрлийн мансууруулах бодисын агууламжтай ургамлыг түүж хатааж хэрэглэх, түүнээсээ бусдад өгөх, худалдаалах, мөн мансууруулах үйлчилгээтэй

морфин, промедол, кодеин зэрэг эм, тариаг хэрэглэх, бусдад зарж борлуулах зэргээр гэмт хэрэг үйлджээ.

4.2.2 2002 оны Эрүүгийн хуулиар хянан шийдвэрлэсэн мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөт эм, бэлдмэл, бодистой холбоотой хэргийн судалгаа

2002 оны Эрүүгийн хуулийн 21 дүгээр бүлэг “Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг”-т хамаарах 188 дугаар зүйлд Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, хар тамхи, мансууруулах буюу хордуулах, цацраг идэвхт, тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлэх гэмт хэргийг зүйлчилсэн. Эрүүгийн хуулийн 188 дугаар зүйлийн 188.1-д “Галт зэвсэг, байлдааны галт хэрэгслийг хууль бусаар Монгол Улсын хилээр нэвтрүүлсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”, 188.2-т “Хар тамхи, мансууруулах буюу хордуулах, ... бодисыг хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлсэн бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”, 188.3-т “Энэ хэргийг давтан буюу бүлэглэж, урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, эсхүл их хэмжээтэйгээр, түүнчлэн албан тушаалтан албан тушаалынхаа байдлыг ашиглаж үйлдсэн бол арваас дээш хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”,

188.4-т “Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол хориос дээш хорин таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж тус тус заасан.

22 дугаар бүлэг “Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг”-т хамаарах 192 дугаар зүйлд Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах гэмт хэргийг зүйлчилсэн


Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйлийн 192.1-д “Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг

борлуулах зорилгогүйгээр хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”, 192.2-т “Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг борлуулах зорилгоор хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, борлуулсан бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”, 192.3-т “Энэ хуулийн 192.2-т заасан хэргийг: 192.3.1.онц их хэмжээгээр; 192.3.2.насанд хүрээгүй хүн оролцуулж; 192.3.3.онц аюултай гэмт хэрэгтэн; 192.3.4.давтан; 192.3.5.урьдчилан үгсэж тохиролцсон буюу зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ “ гэж заасан болно.

2002-2013 оны 03 дугаар сар хүртэлх хугацаанд дүүргийн шүүхүүд тухайн төрлийн гэмт хэрэгт 99 хүнд холбогдох 48 хэргийг шийдвэрлэсэн нь нийт шийдвэрлэсэн хэргийн 61 хувийг эзэлж байна.

График 4

2002 оны Эрүүгийн хуулийн 192, 188 дугаар зүйлээр шийдвэрлэгдсэн хэргийн судалгаа



Үүнээс 2 хүнд холбогдох 1 хэргийг 1986 оны Эрүүгийн хуулийн 254 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шийдвэрлэжээ.

Шүүхээр шийдвэрлэгдсэн 90 хүнээс 83 хүнд ял шийтгэл оногдуулж, 7 хүнд холбогдох үйлдлийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.2-т заасан нэмэлт нотлох баримтыг цуглуулах бүхий л ажиллагааг хийсэн боловч сэжигтэн, яллагдагч гэмт хэрэг үйлдэхэд оролцсон болох нь нотлогдоогүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгон цагаатгасан.

Хүснэгт 6

2002-2013 онд дүүргийн шүүхээр хянан шийдвэрлэсэн мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой хэргийн судалгаа

Шийдвэрлэсэн он	2002-2013								НИЙТ
	254-1	188.2	188.3	192.1	192.2	192.3.1	192.3.4	192.3.5	
Зүйл анги									
Хэрэг	1	1	5	37	1	2	-	1	46
Хүн	2	1	13	73	4	2	1	3	90
Хэрэгсэхгүй болгосон, цагаатгасан хүн				6	1				7
Эрүүгийн хуулийн өөр зүйлд заасан гэмт хэрэгт давхар ял шийтгэгдсэн		1	4	2					7
Ял шийтгүүлсэн хүн	2	1	4	67	3	2	1	3	83

Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйлд зааснаас гадна мөн хуулийн

- 91 дүгээр зүйлийн 91.2.12, 145 дугаар зүйлийн 145.1 дэх хэсэгт зааснаар 1 хүн,
- 148 дугаар зүйлийн 148.3 дахь хэсэгт зааснаар 1 хүн,
- 188 дугаар зүйлд зааснаар 5 хүн тус тус давхар зүйлчлэгдэн ял шийтгэгдсэн байна.


Тухайлбал, Чингэлтэй дүүргийн шүүхийн 2008 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 214 дүгээр шийтгэх тогтоолтой хэрэгт Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2.12, 145 дугаар зүйлийн 145.1, 192 дугаар зүйлийн 192.1 дэх хэсэгт зааснаар ял шийтгэгдсэн Ц нь Соёлын коллежийн хөгжмийн багшийн ангид суралцаж байсан, рок хөгжим сонирхдог залуу байх бөгөөд тэрээр 2003 оноос эхлэн мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх “тетрагидро каннабинол делта 9” бодис бүхий олсны төрлийн ургамал хэрэглэдэг, үүний улмаас каннабинойдын шалтгаант сэтгэцийн болон төрх үйлийн эмгэг өвчтэй болсон. Уг өвчин нь 2003 оноос каннабисын төрлийн бодисыг хэрэглэж эхэлснээс үүссэн болох нь шинжээчийн дүгнэлтээр тогтоогдсон.

Улмаар Ц нь мансуурсан үедээ өөрийн найз охин Э-г онц харгис хэрцгий аргаар алсан, бусдын эд хөрөнгийг хулгайлсан гэмт хэргийг тус тус үйлдэж ял шийтгэгджээ.

Нийт ял шийтгэгдсэн 83 хүний 56 хүн нь мансууруулах бодисыг хэрэглэж үзсэнээс 34 хүн нь сонирхож буюу тохиолдлын журмаар татаж, хэрэглэж үзсэн, 15 хүн нь хэд хэдэн удаа хэрэглэж байсан, 7 хүн нь 2-3 жил хэрэглэсэн, уг бодист донтох шинжтэй болсон нь шинжээчийн дүгнэлтээр мөн тогтоогдсон байна.

График 5

Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөт эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан шалтгаан /2002-2013 он/



Ял шийтгүүлэгчдийг насны ангиллаар авч үзвэл 17-18 насных 4,0 хувь буюу 4 хүн, 19-36 насных 86,0 хувь буюу 79 хүн, 36-аас дээш насных 9,0 хувь буюу 8 хүн байна.

Хүснэгт 7


Эрүүгийн хуулийн 188-196 дугаар зүйлүүдэд заагдсан гэмт хэрэгт ял шийтгүүлэгсдийн судалгаа /2002-2013 он/

Зүйл анги	Ял шийтгүүлсэн хүн	Хүйс /эм/	Урьд ял шийтгүүлсэн эсэх	Гадаадын иргэн	Нас			Боловсрол				Эрхэлдэг ажил		
					16-18	19-36	36-аас дээш	Дээд	Дунд	Бага	Боловсрол-гүй	16-18	19-36	36-аас дээш
х 254-1	2						2	2						2
188.2	1					1		1						1
188.3	13		1	1		11	2	6	7				9	4
192.1	67	3	13	5	4	62	1	16	50	1	2	13	9	40
192.2	3		1	2		2	1		1					1
192.3.1	2		1				2	1	1					2
192.3.4	1					1			1			1		
192.3.5	3					3		1	2				1	2

Шүүхээс ял оногдуулсан байдлыг судалж үзэхэд торгох ялаар 1 хүн, баривчлах ялаар 36 хүн, Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2.12-д заасан гэмт хэрэгт давхар ял шийтгүүлсний улмаас цаазаар авах ялаар 1 хүн, хорих ялаар 45 хүн шийтгүүлсэн, үүнээс 1-3 жил хорих ялаар 30 хүн, 3-5 жил хорих ялаар 3 хүн, 5-10 жил хүртэл хорих ялаар 2 хүн, 10 жилээс дээш хорих ялаар 19 хүн шийтгүүлсэн бөгөөд шүүхээс оногдуулсан хорих ялыг тэнсэж хянан харгалзсан 13, тогтоол биелүүлэхийг хойшлуулсан 1, үлдсэн 40 хүний хорих ялыг биечлэн эдлүүлэхээр тогтоожээ.

График 6

Ял шийтгэлийн судалгаа /2002-2013 он/



Хэргийн зүйлчлэлийн хувьд Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан үйлдэл нь түүнийг борлуулах зорилготой байсан эсэхээс шалтгаалж Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйлийн 192.1 болон 192.2 дахь хэсэгт заасны аль тохирохоор зүйлчлэн шийдвэрлэдэг.

2002-2012 онд шүүхээр шийдвэрлэсэн хэргийн 10,8 хувь буюу 5 хэргийг прокуророос Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйлийн 192.3.4, 192.3.5-д зааснаар яллах дүгнэлт үйлдэн ирүүлснээс 4 хэргийг “Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг борлуулах зорилгоор хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан” болох нь тогтоогдоогүй,

харин борлуулах зорилгогүйгээр олж авсан, бэлтгэсэн, хадгалсан гэсэн үндэслэлээр Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйлийн 192.1 дэх хэсэгт зааснаар, 1 хэргийг тухайн бодисыг борлуулах зорилготой байсан боловч урьдчилан үгсэн тохиролцсон болох нь тогтоогдоогүй гэсэн үндэслэлээр Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйлийн 192.2 дахь хэсэгт зааснаар тус тус хөнгөрүүлэн зүйлчилж шийдвэрлэсэн байна.

Энэ төрлийн гэмт хэрэгт тухайн мансууруулах бодисын төрөл (мансууруулах, хорт, хүчтэй үйлчлэх), нэр, шинжийг тодорхойлох, түүнчлэн мансууруулах бодис бүхий ургамал мөн бишийг тогтооход зайлшгүй тусгай мэдлэг хэрэгтэй. Иймд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад шинжээчийн дүгнэлт заавал гаргуулах шаардлагатай. Гэтэл шүүхийн шийдвэрийг судлах явцад:

- Сүхбаатар дүүргийн шүүхээр 1999 онд хянан шийдвэрлэгдсэн 136 тоот шийтгэх тогтоолтой эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд оролцсон шинжээчээс "... шаардлагатай тоног төхөөрөмж байхгүй тул мансууруулах бодисын хувь хэмжээ, нэр томъёог нарийн тогтоох боломжгүй, хроматограммын аргаар шинжлэхэд мансууруулах бодисын хольцтой гарсан..." гэж мэдүүлсэн,

- Нийслэлийн шүүхээр 1998 онд хянан шийдвэрлэгдсэн эрүүгийн хэрэгт гаргасан шинжээчийн дүгнэлтээр "Техникийн боломжгүйгээс болж ямар нэртэй, найрлагатай бодис болохыг тогтоож чадаагүй..." гэсэн,


- Чингэлтэй дүүргийн шүүхээр 2008 онд хянан шийдвэрлэгдсэн 219 тоот шийтгэх тогтоолтой эрүүгийн хэрэгт "...бор шаргал өнгийн дугуй шахмал зүйл болон хатаасан ургамал мэт бусад дээжийг "Наркотест"-ээр шалгахад каннабис болох эерэг хариу үзүүлж байна. Баталгаат шинжилгээ хийх техникийн боломжгүй..." гэсэн дүгнэлтүүдийг тус тус гаргасан байна.

1986-2001 онд энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн 52 хүний 57,6 хувь буюу 30 хүн нь Мансууруулах бодисыг борлуулах зорилгоор хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, борлуулсан гэх 1986 оны Эрүүгийн хуулийн 254 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар ял шийтгүүлсэн бол 38,4 хувь буюу 20 хүн нь борлуулах зорилгогүйгээр хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, борлуулсан гэж ял шийтгэгдэж байжээ.

Харин 2002-2013 оны байдлаар гаргасан судалгаанаас харахад нийт ял шийтгүүлэгсдийн 16,8 хувь буюу 14 хүн борлуулах зорилгоор, 83,1 хувь буюу 69 хүнийг борлуулах зорилгогүйгээр мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, ял шийтгэл оногдуулсан байна.

График 7

Мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан гэмт хэрэг үйлдэгчдийн сэдэлт, зорилго /1986-2013 он/



Дээрх байдлаас харахад сүүлийн жилүүдэд мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг борлуулах зорилгогүйгээр сонирхож хэрэглэсэн, хэрэглэхээр бэлтгэж, олж авсан, дамжуулсан үйлдлүүд зонхилж байна.

Тухайлбал, Баянзүрх дүүргийн шүүхийн 2011 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 218 дугаар шийтгэх тогтоолтой хэрэгт шүүгдэгч Э.С-ийн мэдүүлэг: Дархан-Уул аймагт очоод зураг аваад гадуур явж байгаад амьд хөгжим сонсдог хэдэн залуучуудтай санамсаргүй танилцаад тэр залуучууд шинэ Дарханы цаашаа яваад мансууруулах үйлчилгээтэй ургамал ургадаг гээд зааж өгсөн. Би нэг тор орчмыг гэртээ түүж ирээд тортой нь орхиод муудаад ялзарсан байсан тул үүдний амбаарын дээвэр дээр хатаах гэж дэлгэж тавьсан. Тэр авчирсан ургамлаасаа Г.Б-тэй хамт татсан. Г.Б тэр чигтээ аваад явсан байсан. Өөр хүнд өгөөгүй, зарсан зүйл байхгүй гэх,

Шүүгдэгч Г.Б-ийн мэдүүлэг: Би 1 жил гарангийн өмнө хэрэглэж байсан. Шоу, party дээр тохиолдлоор хүмүүстэй таарч хамт хэрэглэх үү гэхээр нь хэрэглэж байсан. Анх цаасанд боогоод хэрэглэж байсан. Хөгжим гоё сонсогддог гэж байсан. 9 дүгээр сард Э.С-тэй хэрэглэж байсан гэх,

Шүүгдэгч Б.И-ийн мэдүүлэг: Анх 2010 оны 7 дугаар сард би Их дэлгүүрийн урд байдаг том асарт гитараа үүрээд явж байхад хэдэн амьд хөгжим сонирхдог залуус гитарыг чинь үзье гэсэн. Тэр залуус их нээлттэй залуучууд байсан учраас танилцсан. Тэд нар гаансанд хийгээд инээдэг өвс гээд татаад байсан. Би татаж үзсэн, надад жоохон өгчих гэсэн чинь зүгээр л өгсөн. Надад мансууруулах өвс гэж хэлээгүй, инээдэг өвс гэж хэлсэн. Хүмүүсийн хажууд татаад байхаар нь би болохгүй зүйл гэж мэдээгүй. Тэр өдрөөс хойш тэр залуутай Монгол шилтгээнд таарсан. Тэгээд нөгөө инээдэг өвснөөс чинь байна уу гээд авсан гэх,

Хар тамхи, мансууруулах үйлчилгээ бүхий каннабис /Тетра гидро каннабинол/ бодис агуулсан хагас боловсруулсан бэлдмэлийг хэрэглэх, бусдад борлуулах зорилгоор БНХАУ,

Филиппин зэрэг улсаас худалдан авч Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн гэж мэдүүлсэн тохиолдол 3, бусад нь манай улсын нутаг дэвсгэр дээр бусдаас худалдан авах буюу мансууруулах үйлчилгээ бүхий Монгол Улсын зарим бүс нутагт тархан ургадаг Каннабисийн төрлийн мансууруулах бодисын агууламжтай ургамлыг түүж хатааж хэрэглэх, түүнээсээ бусдад өгөх, худалдаалах, мансууруулах үйлчилгээтэй морфин, моноацетилморфин, амфетамин зэрэг эм, бэлдмэл, бодисыг бусдад зарж борлуулах зэргээр гэмт хэрэг үйлджээ.


Тухайлбал, Сонгинохайрхан дүүргийн шүүхийн 2011 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 78 дугаар шийтгэх тогтоолтой хэргийн шүүгдэгч Ц.Э-гийн мэдүүлэг: 2010 оны 10 дугаар сарын 20-ны өдөр би гэртээ байж байтал Өөбөө гэх залуу уулзахаар яриад Хорооллын эцсийн буудал дээр уулзсан. Тэгсэн Өөбөө би тэнэг болчихсон байна уу гэж асуухаар нь яасан гэсэн чинь манай найз Сэлэнгээс ирсэн юм. Тэгээд авч ирсэн, бид нар сая караокед орж татсан юм гээд намайг татах уу гээд бид хоёр хорооллын эцэст буудалд орж татсан гэх,

Хэргийн материалаас үзэхэд мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис ялангуяа манай орны нутаг дэвсгэрт зэрлэг байдлаар ургадаг олсыг хортой, хэрэглэж болохгүй гэж үзэхээсээ илүү хууль эрх зүйн мэдлэг сул, хайхрамжгүй, гэнэн томоогүй байдлаасаа болж шохоорхон, цааш борлуулах зорилгогүйгээр бие биедээ дамжуулан өгөх, авах, ургадаг газраас нь очиж түүж бэлтгэх, хэрэглэх зэрэг байдлаар хэрэгт холбогдох байдал гарч байна.

Мөн сүүлийн жилүүдэд энэ төрлийн гэмт хэрэгт холбогдогсод насны хувьд залуужсан, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын талаар интернэтээр болон бие биенээсээ дам мэдээлэл олж цуглуулан сонирхон хэрэглэж үзсэн гэж мэдүүлсэн байдал нэмэгджээ.

График 8

Ял шийтгүүлэгчдийн нас



Тухайлбал, Баянзүрх дүүргийн шүүхийн 2009 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 455 дугаар шийтгэх тогтоолтой хэргийн шүүгдэгч Б.Б-гийн мэдүүлэг: 2009 оны 8 дугаар сарын 11-ний өдөр компьютер дээр тоглоом тоглож байхад Г.Г, Ө.Д нар нь интернэтэд м үзэж байсан. Бид нарын сонсдог хамтлагийг харж байсан. Тэнд хар тамхины талаар янз бүрийн мэдээлэл байсан. Дараа нь 2009 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Ө.Д-тэй Г.Г-ийн машинаар 22 цагийн үед Баруун хараа гэдэг газар руу хар тамхины ургамал түүхээр явсан гэх,

Шүүгдэгч Ө.Д-гийн мэдүүлэг: Б.Б, Г.Г бид гурав интернэт ороод дуу сонсож байж байгаад Баруун Хараагийн тэнд Хятадууд хар тамхи тарьдаг гэсэн сайт уншсан. Үүнийг уншиж байгаад тухайн каннабис гэдэг ургамлыг түүе гэж бодоод 2009 оны 8 дугаар сарын 12-ны орой 22 цагийн үед Г.Г-ийн машинаар бид гурав хар тамхины ургамал түүх гэж явсан юм гэх,

Шүүгдэгч Г.Г-ийн: 2009 оны 8 дугаар сарын 12-ны орой Ө.Д, Б.Б нарын хамт Дарханы Баруун хараа руу явж хар тамхины ургамал болох каннабисийг түүхээр өөрийн эзэмшлийн Гранд марк 2 машинтайгаа 22 цагийн үед хотоос гарч очсон. Тэгээд очоод замын хажуугийн жалганаас бид гурав 4 тор каннабис түүсэн...09 цагийн үед машинаа засварын газарт өгөөд, тортой өвсөө аваад такси барих гэж байгаад цагдаад баригдсан гэх,

Сүхбаатар дүүргийн шүүхийн 2008 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 33 дугаар шийтгэх тогтоолтой эрүүгийн хэргийн шүүгдэгч Х.Л-ийн мэдүүлэг: Би Дархан, Сэлэнгэ аймгуудаар ургадаг “намир цэцэг” гэх өвсөн ургамлыг хэрэглэж үзсэн. Харин бусдад борлуулсан, хадгалсан, бэлтгэсэн зүйл байхгүй. Гэрт нэгжлэг хийх явцад хураагдсан бодис бол энэ намир цэцгийн тоосонцор. Энэ зун Дархан явахдаа түүж аваад хэрэглээд үлдсэн нь юм. Хааяа нэг тайвшрахын тулд тамхинд ороож татаж хэрэглэдэг, эсвэл тугалган цаасан дээр тавиад доороос нь галаар төөнөж утааг сорж хэрэглэдэг. Уг өвсийг бурханаас дэлхийд ургуулсан. Би мансууруулах бодис биш гэж үздэг, хэрэглэсэн үед гайхамшигтай хөгжмийн аянд амьдарна. Өөр ямар нэгэн зүйл хэрэглэдэггүй, өвсөө хайрлаж хүндэлдэг гэх.

Баянзүрх дүүргийн шүүхийн 2003 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 267 дугаар шийтгэх тогтоолтой хэргийн шүүгдэгч А.Н-ийн мэдүүлэг: 2002 оны 8 дугаар сарын дундуур Х-ийн хамт явж байхдаа 15-р хорооллын танктай хөшөөний дэргэдээс ногоон өнгийн ургамал түүж авсан. Урьд нь телевизэрээр ийм ургамал хэрэглэвэл хөгжилтэй сэргэлэн болдог гэж үзэж байсан. Тэгээд тагтан дээр тавьчихсан байж байгаад саяхан хэрэглэх гэж байгаад цагдаад баригдсан гэх,

Энэ төрлийн гэмт хэрэгт хохирогч байдаггүй онцлогтой бөгөөд хэрэг илрүүлэлтийн байдлыг авч үзэхэд нийт хэргээс 2,8 хувь буюу 2 хэрэг нь л ар гэрийнхнийх нь мэдээллээр илэрсэн. Үлдсэн хэргүүд нь давхар гэмт хэрэгт холбогдсон бол тэдгээр хэргийн хохирогч нарын мэдүүлгээр илрүүлсэн бол бусад тохиолдолд гудамж талбайд захиргааны зөрчил гарган саатуулагдах үед биед нь үзлэг хийхэд илэрсэн, гэрч нарын мэдүүлгээр илрүүлсэн, гүйцэтгэх ажиллагаанышугамаар мэдээлэл цуглуулсан зэрэг тохиолдлууд байна.

Тухайлбал, Сонгинохайрхан дүүргийн шүүхийн 2009 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн 11 дүгээр шийтгэх тогтоолтой хэргийн шүүгдэгч С.А-ийн мэдүүлэг: 2008 оны 1 дүгээр сард Сүлжмэлийн автобусны буудал дээр нэг хүн гар өргөж суусан.

Тэр хүн Дарь-Эхийн тэнд сэлбэгийн төв орж машиндаа шаариг аваад буцаад Драгон төв орсон. Тэгээд чи инээдэг өвс гэж сонссон уу гэхээр нь би тэр тухай сонсоогүй, ямар юм байдаг юм бэ үзье гэсэн чинь машин дотроосоо янжуур тамхины хайрцагтай дүнсэн тамхи шиг зүйл гаргаж ирээд үзүүлсэн. Тэгэхээр нь би сонирхоод нэгийг татаж үзсэн. Тэгэхэд надад юу ч мэдрэгдээгүй. Түүнээс хойш 2 удаа хэрэглэсэн. Миний толгой эргээд дотор муухайраад байсан. Тэгээд тэр өвсийг машиныхаа хаалганд хийгээд мартсан байсныг манай ээж миний машиныг цэвэрлэж байгаад олж авсан юм гэх,

Гэрч Б.Ч-ийн мэдүүлэг: Би хүүгийнхээ машиныг цэвэрлэж байгаад машиных нь хаалганаас тамхины хайрцагтай арц шиг нунтаг зүйл олсон. Тэгээд арц юм уу гээд үнэрлэсэн чинь арц биш байсан. Тэгэхээр нь ноцтой юм байна гэж бодоогүй аваад гэрийнхээ унинд хавчуулсан байсан. Гэхдээ би хүүгээ гэмт хэргийн ертөнцөд хөл тавьчих вий гэсэндээ тэр зүйлийг авч явж цагдаад аваачиж өгсөн гэжээ.

Сүүлийн жилүүдэд Эрүүгийн хуулийн 188 дугаар зүйлд заасан хар тамхи, мансууруулах бодисыг хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлэх гэмт хэрэг нэмэгдэх хандлагатай байна. Энэ төрлийн гэмт хэргийн онцлог нь ихэвчлэн урьдчилан үгсэн тохиролцсон зохион байгуулалттай бүлгийн хэлбэрээр үйлдэгдэж байгаа бөгөөд манай 2 хөрш болох БНХАУ, ОХУ нь энэ төрлийн бодисын томоохон хэрэглэгч, зах зээл байгаатай холбоотой гэж үзэж байна. Энэ төрлийн гэмт хэрэгт холбогдож буй манай улсын иргэд дийлэнх нь тээвэрлэгч гэсэн ангилалд хамаарах болоод байна. Энэ төрлийн хууль бус үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалттай гэмт бүлгүүдийн зүгээс Монгол Улсын иргэдийн Зүүн Өмнөд Азийн орнуудад визгүй зорчих боломжтой байдал, гэнэн итгэмтгий зан, амар хялбар аргаар мөнгө олох гэсэн сул талуудыг нь ашиглан хууль бус эргэлтэд татан оролцуулах болсны зэрэгцээ бизнесийн болон хувийн шугамаар гадаад улс руу зорчих явцдаа хууль бус үйлдэлд татагдан орох, ялангуяа мансууруулах бодисын тээвэрлэлттэй холбоотой асуудлаар

бусдад санаатай болон санамсаргүй байдлаар ашиглагдан тухайн улсын хуулийг зөрчих, орлого багатай, амьдрал ядуу хүмүүс гэмт хэрэгт холбогдох явдал сүүлийн жилүүдэд нэмэгдэх хандлагатай байна.

Тухайлбал, Баянзүрх дүүргийн шүүхийн 2013 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 41 дүгээр шийтгэх тогтоолтой хэргийн шүүгдэгч Ч.Э-гийн мэдүүлэг: Манай охин ажлаасаа 3 хоногийн чөлөө аваад Гуан Жоу руу брэндийн бараа аваачиж өгчихөөд ирдэг юм уу гэхэд нь би ээлжийн амралттай байсан болохоор аав нь зүгээр байж байхаар замын зардлыг нь даадаг юм бол газар үзчихээд ирье гээд явсан. Гэтэл 12 дугаар сарын 07-ны өдөр гааль дээр саатуулагдсан. Би өөрөө энэ талаар мэдээгүй, пүүз, хэдэн срочкин цамц байсан. Тэгээд гаалийн шалгадаг зүйл дээр би баригдсан. Тэгээд миний авч явсан цүнхнээс нэг цэнхэр, нэг ногоон өнгөтэй зүйл гарч ирсэн. Гаалийн ажилтан өөрөө хутгаар зүсэж онгойлгосон. Тэгээд гялгар ууттай 3 ширхэг юм гарч ирсэн. Тэгээд нэгийг нь цагаан өнгөтэй зүйлийг хуруу шилэнд хийж шалгахад хар цай шиг өнгөтэй болсон. Тэгээд баригдсан гэсэн мэдүүлэг гэх,

Шүүгдэгч Ж.Н-ийн мэдүүлэг: 2011 оны 11 сарын 10-ны үеэр манай дүү надад “хамт ажилладаг охин гадаадаас брэндийн бараа авч оруулж ирж байгаа гэнэ, тэгээд гадаад хэлтэй, англи хэл мэддэг хүн хэрэгтэй байна гэсэн, та явах уу” гэсэн санал тавьсан. Гадаадаас брэндийн бараа оруулж ирэх юм аа, та очоод аваад ирэх үү гэхээр нь би тэлье гээд тэр өдөртөө онгоцны билетээ худалдаж авсан. Тэгээд маргааш орой 5 цагийн үед Малайз руу ниссэн байгаа. Энэ явцдаа би яг тэр өгсөн цүнхтэй барааг нь Малайзын гаалиар ороход нэг шалгуулаад бүртгүүлэхэд нэг шалгуулсан. Нийт 2 удаа шалгуулсан. Тэгээд Солонгос Улсад ирээд дахин гаалиар орсон. Монголдоо мөн гаалиар шалгуулж орж ирсэн. Миний авч ирсэн бараа нь гүччи фирмийн сибирийн гутал, жоржи армани гэсэн брэндийн цамц, футболка байсан. Миний хувьд анхнаасаа явахдаа ийм зүйл байгаа, тээвэрлэнэ гэж бодоогүй, тээвэрлэх зорилготой ч байгаагүй. Хэрвээ би

гадаадад байхдаа тийм юм байна гэж мэдсэн бол наашаа оруулж ирэхгүй байсан. Гаалиар орохоос ч айх байсан гэх мэдүүлэг,

Яллагдагч Г.Г мэдүүлэхдээ: 2011 оны 9 дүгээр сарын 06-ны өдөр Н-ээс 2 цүнх аваад Улаанбаатараас нисээд Гуан Жоуд буусан. Тэгээд Гуан Жоуд очоод Н эгч бид хоёрын авч ирсэн цүнхтэй юмыг аваад явсан. Тэгээд Н эгчид мөнгө өгөөд байх шиг байсан. Монголд ирээд 700 ам.доллар авсан гэжээ.

Үүнээс гадна монгол иргэд, охид, эмэгтэйчүүд БНХАУ-ын Бээжин, Гуан Жоу, Шэньжэн, Хонконг, Малайз зэрэг улсуудад удаа дараа зорчиж африк гаралтай иргэдтэй харилцаанд орж улмаар мөнгө олох ашигтай саналыг хүлээн авч тэдний эрхшээлд орж хар тамхи, мансууруулах бодис тээвэрлэх ажиллагаанд татагдан орж, цаашлаад монгол иргэдийг элсүүлэн энэ төрлийн гэмт хэрэгт татан оруулах хандлагатай байна.

Дээр дурдсан хэрэгт яллагдагч, шүүгдэгч нар “Мартин” гэгч Африк гаралтай хүнтэй цахим шуудангаар харилцаж урьдчилан үгсэн тохиролцож брэндийн бараа зөөх байдлаар халхавчилж байсан бөгөөд шүүгдэгч С.Н нь 2010 оноос эхлэн 2011 оны 12 дугаар сар хүртэлх хугацаанд өөрийн ах, дүү, хамаатан садан болон бусад нэр бүхий 28 хүнээр сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл буюу хар тамхийг Малайз, Монгол, Хятад улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн.

Мөн Хан-Уул дүүргийн шүүхийн 2013 оны 1 дүгээр сарын 07-ны өдрийн 24 дүгээр шийтгэх тогтоолтой эрүүгийн хэрэгт ял шийтгүүлсэн Филиппин улсын иргэн Э.П.Б, Монгол Улсын иргэн Э.А нар нь БНХАУ-ын Гуан Жоу хотод зорчиж байхдаа Нигер улсын иргэн О.А.Ж гэгчтэй танилцан хар тамхи, мансууруулах бодисын хууль бус наймаанд холбогдож, энэ гэмт хэргийг урьдчилан үгсэн тохиролцож үйлдсэн байна.

4.3 Мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудал

Энэ төрлийн хэргийг зүйлчлэхэд шинжээчийн дүгнэлтийг үндэслэхээс гадна мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын хэмжээг анхаарах ёстой. Хууль тогтоогч Эрүүгийн хуулийн 192.1 дэх хэсэгт “хэмжээ” зааж өгөөгүй тул хүний биед мансууруулах үйлчилгээ үзүүлж чадах тухайн бодисын доод хэмжээнээс “онц их хэмжээ” хүртэлх хэмжээг хамааруулан ойлгох хэрэгтэй ба “онц их хэмжээтэй” бол хэргийг Эрүүгийн хуулийн 192.3.1-д зааснаар хүндрүүлэн зүйлчилдэг.

Нөгөө талаар “онц их хэмжээ”-г ямар шалгуураар тогтоох вэ, энэ тохиолдолд Эрүүгийн хуулийн 29 дүгээр зүйлд заасан хохирлын хэмжээг шалгуур болгон хэрэглэх боломжтой эсэх нь хуульд тодорхой биш байгаа нь мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэргийг шийдвэрлэхэд хүндрэлтэй байдал үүсгэж байна.

Тухайлбал: Нийслэлийн прокурорын газраас, 1961 оны Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенцийн 3 дугаар жагсаалтад орсон, мансууруулах бодис болох морфин, геройны бэлдмэлийг онц их хэмжээтэйгээр буюу 0,523 кг-ыг хууль бусаар олж авч хадгалан улмаар борлуулах зорилгоор бусдад шилжүүлэн өгсөн гэмт хэрэгт Ц.У-д холбогдуулж яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлсэн хэргийг Баянзүрх дүүргийн шүүх 2011 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 417 дугаар шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйлийн 192.3.1-т зааснаар Ц.У-г мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг онц их хэмжээгээр хууль бусаар олж авч, хадгалж, борлуулах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, 11 жил хорих ял оногдуулжээ.

Шүүх “онц их хэмжээ” буюу Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйлийн 192.3.1-т зааснаар зүйлчлэхдээ хавтаст хэрэгт авагдсан ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн газрын “...хар тамхи,

мансууруулах бодисын төрөлд орох геройн нь ...дэлхийн улс орнуудын хэмжээнд 1 кг нь 300-250.000 ам.долларын хооронд хэлбэлзэж байна. Монгол Улсын хувьд тогтоосон ханш байхгүй ба нэг удаагийн хэрэглээний геройны үнэ нь 300-500 мянган төгрөгөөр үнэлэгдэж байна...” гэсэн тодорхойлолтыг үндэслэж 0.523 кг мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангид заасан онц их хэмжээнд тооцогдож байна гэж шүүх бүрэлдэхүүн хэрэг шийдвэрлэхдээ дүгнэсэн байна.

Гэтэл Улсын Дээд Шүүх 2011 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 653 дугаар тогтоолоор хэргийг “гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг үнэлгээ хийх эрх бүхий байгууллагаар бус Эрүүгийн цагдаагийн газраар тогтоолгосныг залруулах, ...хэрэгт хураагдсан мансууруулах бодисын нэг удаагийн хэрэглээ нь ямар хэмжээтэй, ямар үнэтэй байдгийг тогтоолгох” зэрэг нэмэлт ажиллагаа хийлгэхээр мөрдөн байцаалтад буцаасан.

Улмаар мөрдөн байцаалтын явцад 0.523 кг мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 29 дүгээр зүйлд заасны дагуу мөнгөн илэрхийллээр үнэлж тогтоох боломжгүй байсан тул үнэлгээг Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенцийн жагсаалтад орсон мансууруулах эм болон бодисын үнэ ханшийн талаарх судалгааг НҮБ-ын хар тамхины эсрэг тэмцэх албанаас гаргасны дагуу 0.523 кг бүхий дээрх бодисыг онц их хэмжээтэй гэж үзэн Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйлийн 192.3.1-т зааснаар яллах дүгнэлт үйлдэн дахин шүүхэд шилжүүлжээ.

Баянзүрх дүүргийн шүүх 2012 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 180 дугаар шийтгэх тогтоолоор Ц.У-г мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг онц их хэмжээгээр хууль бусаар олж авч хадгалсан, борлуулах зорилгоор бусдад шилжүүлсэн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйлийн 192.3.1-т зааснаар 11 жил хорих ял оногдуулж, давж заалдах шатны шүүх, хяналтын шатны шүүхээс шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна.

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус наймаа эрхэлдэг гадаадын бүлэглэлүүдээс Монгол Улсын иргэдийг энэ төрлийн гэмт хэргийн ноцтой хэлбэр болох борлуулах болон энэ зорилгоор мансууруулах бодис бэлтгэх, тээвэрлэх, илгээх үйл ажиллагаанд татан оролцуулах болсон, манай улсын нутаг дэвсгэрт гадаадаас мансууруулах бодис нэвтрүүлэхийг, дамжин өнгөрүүлэхийг оролдох болсон, Монгол Улс хар тамхины донтолт түгээмэл хоёр том гүрний дунд, Ази Европ тивийг холбох агаарын болон төмөр зам, авто замыг нутгаараа өнгөрүүлдгийн хувьд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисыг их хэмжээгээр тээвэрлэсэн, илгээсэн хэргүүд гарч болзошгүйг анхааран өөрийн улсын Эрүүгийн хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд хууль бусаар тээвэрлэгдсэн, бэлтгэгдсэн мансууруулах бодисын хэмжээнээс хамааруулан хэргийг зөв зүйлчилдэг байх нь цаашдын болзошгүй эрх зүйн хийдэл, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны гацаа, хуулийн маргаантай асуудлууд үүсэхээс сэргийлэх ач холбогдолтой.

Мөн энэ нь Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж буйд өгөх олон улсын үнэлгээнд ч тэр, энэ төрлийн гэмт хэрэгт холбогдон харь улсын хуулийн хатуу шийтгэлийг хүлээж болзошгүй байгаа манай иргэдийн эрх зүйн байдалд ч эерэг нөлөөлөх учиртай.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ТАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Хүний эрх, эрх чөлөөг тууштай хамгаалах явдал нь юуны өмнө хүний эрх зөрчигдсөн тухай асуудлыг шалгаж, шийдвэрлэхдээ зөрчигдсөн эрхийг бүрэн дүүрэн сэргээн эдлүүлэх хамгийн үр дүнтэй арга замыг тодорхойлж, ажиллахыг хэлдэг. Хууль тогтоогч, бодлого боловсруулагчид гаргаж буй шийдвэрийнхээ үр дагаврыг бүх талаас нь сайтар нягталж, хэлбэрийн төдий бус, асуудлыг аль болох бүрэн төгс шийдвэрлэх боломжтой шийдлийг олох нь хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс сэргийлэх хамгийн том хүчин зүйлс болно. Хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуульд заасан хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг боловсронгуй болгосноор хүний эрх зөрчигдөхөөс сэргийлэх, зөрчигдсөн тохиолдолд сэргээн эдлүүлэх арга зам тодорхой болно гэж үзэж байна. Энэхүү судалгааны үр дүнг дүгнэж, энэ төрлийн гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр дараах саналуудыг дэвшүүлж байна.

ДҮГНЭЛТ 1. Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйлд заасан “Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан, борлуулсан” гэмт хэрэг үйлдсэн этгээдээс сэдэлт, зорилгыг тодруулахад бусдад уруу татагдаж сонирхсон, хөгжим гоё сонсогддог, тайвширдаг, онгод ордог тул, эсхүл өвчнөө намдаах зорилгоор олж авч хэрэглэсэн гэх тайлбарыг өгсөн байдаг.

Гэтэл мансууруулах бодисын хууль бус эргэлт нь хүн амын дунд хяналтгүйгээр тархаж, тэдний амь нас, эрүүл мэнд, хувь хүн, гэр бүл, нийгэм сэтгэл зүйн эрүүл уур

амьсгал, цаашилбал улс орны үндэсний аюулгүй байдал, эдийн засаг, улс төр, нийгмийн дэг журамд хамгийн ноцтой сөрөг нөлөө үзүүлдэгт энэ төрлийн гэмт хэргийн нийгмийн хор аюул оршино гэж үздэг. Мансууруулах бодисыг хууль бусаар тээвэрлэх, худалдаалах, хэрэглэх явдал нь гэмт хэрэг үйлдэгдэх, цаашилбал Монгол Улсад энэ чиглэлийн дагнасан зохион байгуулалттай гэмт бүлэг бий болох, хөгжих таатай нөхцөл бүрдүүлэх үр дагаврыг агуулж байдаг.

Монгол Улсын газар нутагт олсны төрлийн ургамал тархан ургаж, тухайн зэрлэг олсны төрлийн мансууруулах бодисын агууламжтай ургамлыг мансуурагч этгээдүүд хууль бусаар тарьж ургуулах, түүх, бэлтгэх, боловсруулах зэрэг гэмт хэргийн шинжтэй үйлдэл явуулж эхлэхийн зэрэгцээ зэрлэг олс төрлийн ургамал ургадаг газар нутгийн байршлыг хууль сахиулагч нараас илүүтэй судалж мэдсэн байгаа нь тухайн төрлийн гэмт хэрэгт холбогдсон этгээдүүдийн байцаалт, мэдүүлгээс ажиглагдаж байна.

Түүнчлэн мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтээр мэргэшсэн үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн үйл ажиллагаанд Монгол Улсын иргэд ихээр холбогдох болж, гадаад орнуудад ял шийтгүүлэх тохиолдлууд ч гарсаар байна.

Монгол Улсын шүүхээс тухайн төрлийн гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд тухайн мансууруулах үйлчилгээтэй гэх бодисын найрлагад Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц, Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц /1961 оны 3 дугаар сарын 25-ны өдөр баталж, 1964 оны 12 дугаар сарын 13-ны өдөр хүчин төгөлдөр болсон, 1972 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн протоколоор нэмэлт өөрчлөлт оруулж, уг протокол нь 1975 оны 8 дугаар сарын 8-ны өдөр хүчин төгөлдөр болсон/, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц²⁹ /1988 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталж, 1990 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр хүчин төгөлдөр болсон/, мөн “Мансууруулах эм,

²⁹ “Төрийн мэдээлэл” эмхтгэл. Тусгай дугаар. IV боть. 2006. 1033-1063 дахь тал

сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль³⁰ болон холбогдох бусад хэм хэмжээ тогтоосон актад заасан тодорхойлолт, ухагдахуунаас гадна мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээ бүхий бодис агуулагдсан эсэх талаар шинжээчийн дүгнэлтийг үндэслэх нь зүйтэй ч техник, тоног төхөөрөмж, мэргэшсэн шинжээч дутмаг зэрэг байдлын улмаас зарим тохиолдолд шинжээчийн дүгнэлт хангалттай нотлох баримт болж чадахгүй тохиолдол гарч байна.

САНАЛ 1. Иймд хууль сахиулагч нар болон хуульч нарын мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлийн талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, мөрдөн байцаалтын ажиллагаанд шинжлэх ухаан, технологийн ололт амжилтыг бүрэн дүүрэн ашиглах чадвар, боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр Хууль зүйн яамнаас тодорхой бодлого, хөтөлбөр гаргах шаардлагатай байна. Тус бодлого, хөтөлбөрийн үр дүнд техник хэрэгсэл, тоног төхөөрөмж сайжирч, шинжээч, хууль сахиулагч нарын мэдлэг, ур чадвар энэ төрлийн хэргийг мэргэжлийн түвшинд шалгаж чадахуйцаар дээшилж, үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй бодитойгоор тэмцэж чадах юм.

ДҮГНЭЛТ 2. Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйлд заасан “Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг бэлтгэсэн, олж авсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, борлуулсан үйлдлүүд нь тус тусдаа гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг агуулдаг. Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйлийн 192.1 болон 192.2 дахь хэсэгт заасан гэмт хэргийн диспозиц шинжүүд нь борлуулах зорилго агуулсан эсэхээрээ ялгаатай байх тул гэмт хэрэгтэн дээрх 2 зүйл хэсэгт заасан хэргийн аль алиныг үйлдсэн бол эдгээр нь нийлмэл гэмт хэргийн шинжийг агуулж байна.

Гэвч “Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг “олж авсан” гэдэгт ямар үйлдлийг хамааруулж үзэх нь хуульч нарын дунд маргаан өрнүүлж байдаг. Өөрөөр хэлбэл “Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл,

³⁰ “Төрийн мэдээлэл” эмхтгэл. 2002.12.13 №46

бодисыг тухайн этгээд зөвхөн өөрөө биечлэн худалдаж авсныг “олж авсан” үйлдэлд хамааруулна гэж зарим хуульчид үздэг байхад, харин зарим хуульчид худалдаж авахаас бусад аргаар гартаа оруулсан байхаар ойлгох нь бий.

Харин онолын хувьд “Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг “олж авсан” гэдэгт түүнийг худалдан авсан, эсхүл ямар нэг үүргийн гүйцэтгэл, үйлчилгээ үзүүлсний төлбөрт, эсхүл өр төлбөрт тооцож авсан, мөн ямар нэг эд зүйлээр сольж авсан үйлдлийг хамааруулан ойлгохоос гадна гээгдсэн мансууруулах бодисыг олж аван өөрийн болгосон, мөн мансууруулах бодис агуулсан зэрлэг ургамлыг түүж авсан зэрэг үйлдлүүдийг ойлгох бөгөөд түүнийг эзэмшилдээ авч, захирах зарцуулах бодит боломж үүссэн үеэс гэмт хэрэг төгссөнд тооцно. Харин мансууруулах бодис олж авахаар бусдад мөнгө өгсөн боловч түүнээс үл хамаарах нөхцөл байдлын улмаас авч чадаагүй бол гэмт хэрэг үйлдэхээр завдсан гэж үзнэ.

САНАЛ 2. Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах зэрэг үйлдлүүд нь зорилгоосоо хамаараад харилцан адилгүй, мөн хор уршиг, гэм буруугийн хувьд харилцан адилгүй байх тул зүйлчлэлийг ялгамжтай зүйлчлэх боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна. Одоо практикт хууль тайлбарласан УДШ-ийн 2008 оны 29 дугаар тогтоолоор ойлгож байгаа хэдий ч энэ нь үйлдлийн шинжийг бага боловч ялгасан. Харин хор уршигаар ялгамжтай зүйлчлэх бололцоогүй хэвээр байгаа юм. Тиймээс тус бүрт нь гэмт хэргийн шинжийг тодорхойлж хуульчлах нь чухал. Жишээ нь: Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг “хадгалсан” үйлдэл нь үргэлжилсэн үйлдэлд хамаарах ба гэмт хэрэг илэрснээр төгссөнд тооцогдоно. Өөрөөр хэлбэл үргэлжилсэн, удааширсан, нэгдмэл, нийлмэл гэмт хэргүүдийг бүгдийг нь нэг зүйлээр зүйлчилж байгаа нь гэм бурууд нь тохирсон, ялгамжтай байх зарчмыг алдагдуулж байгаа юм.

ДҮГНЭЛТ 3. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хэт ерөнхий томьёолсноос болж харилцан адилгүй, ялгамжгүй нийтлэг нэг гэмт хэргийн зүйлчлэлээр ял шийтгэж байгаа нь практикаас харагдаж байна. Гэтэл хууль зүйн болон эрүүл мэндийн шинжлэх ухааны үүднээс авч үзвэл мансууруулах бодис нь сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бусад бодисоос зориулалт, сэтгэцэд нөлөөлөх байдлаараа илтэд ялгаатай байдаг. Мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын хэмжээг нарийвчлан тодорхойлоогүйгээс ялгамжтай зүйлчлэх боломжгүй байна. Мөн мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын төрөл, хор хөнөөлийн агууламж, нөлөөллийн зэрэглэл, гарал үүслийн ангилал буюу байгалийн цэвэр байдлаар уу, нийлэгжүүлсэн үү, хагас нийлэгжүүлсэн үү гэх мэт байдлыг харгалзан ял шийтгэл, зүйлчлэл нь харилцан адилгүй байх учиртай. Мансууруулах бодисын ерөнхий ойлголт, хоорондын ялгаа, хор хөнөөл, ангиллын талаар судалгааны нэгдүгээр бүлэгт тодорхой дурдсан болно.

САНАЛ 3. Монгол Улсын Эрүүгийн хуулийг шинэчлэх эсхүл Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд суулгах замаар мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын төрөл, ангилал, хэмжээг хууль зүйн хувьд тодорхой болгож, ялгамжтай зүйлчлэх боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ 4. Мансууруулах бодис болон түүнд донтолтыг судлах Европын төвөөс Европын холбооны гишүүн 16 улсын эрүүгийн хууль тогтоомжид хар тамхитай холбоотой гэмт хэргийн хохирол болон тухайн гэмт хэрэгт холбогдолтой мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хэмжээг тогтоосон байдлыг³¹ судалсан материалд дурдсанаар Европын холбооны улсууд болон АНУ-д гэмт хэргийг мансууруулах бодисын хэмжээнээс хамааруулан ангилан тогтоох шаардлага нь дараах хоёр асуудлыг шийдвэрлэхэд

³¹ European monitoring Centre for Drugs and Drug addiction, Annual report 2012.

чухал нөлөөтэй гэж үздэг ажээ.³² Юуны өмнө олж авсан, хадгалсан байсан ч гэмт хэрэгт тооцогдохгүй (захиргааны зөрчилд хамаарч болох) доод хэмжээг (threshold quantities) тогтоох, хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэхэд шаардлагатай хэмжээ буюу их, онц их хэмжээг тогтоох (large, notably or especially large) асуудал юм. Ингэж ялгах шаардлага нь НҮБ-ийн 1988 оны Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус наймаатай тэмцэх конвенцийн 3 дугаар зүйлийн 3.1, 3.2, 3.3 дахь зүйлд заасан өөрийн хэрэгцээнд хэрэглэх зорилгоор мөн тийм хэмжээтэйгээр уг бодисыг хадгалсан, олж авсан, ургуулсан хэргийг бусдад түгээх, тараах, борлуулах зорилготой үйлдсэн бусад хэргээс онцгой ялгаж зүйлчлэх, эрүүгийн гэмт хэрэгт тооцох асуудлыг шийдвэрлэж байхыг гишүүн улс орнуудад үүрэг болгосон заалтаас урган гарсан байна.

Гэсэн хэдий ч мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын тухай олон улсын үндсэн баримт бичгүүд болох Мансууруулах эмийн тухай 1961 оны нэгдсэн конвенц, 1972 оны дагалдах протоколын хамт, Сэтгэцэд нөлөөт бодисын тухай 1971 оны конвенц, Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын 1988 оны конвенц болон эдгээрийн тайлбаруудад мансууруулах бодисын хэмжээний талаар тодорхой зохицуулалт байхгүй байх бөгөөд дээрх конвенцуудын хэрэгжилтэд хяналт тавьж зөвлөмжүүдийг гаргаж байдаг НҮБ-ын Мансууруулах бодистой холбоотой болон бусад зохион байгуулалттай гэмт хэрэгт хяналт тавих газар (United Nations Office on Drug and Crime-UNODC), НҮБ-ын Мансууруулах бодистой тэмцэх хороо (The Commission on Narcotic Drugs-UNCND) зэрэг байгууллагуудаас ч албан ёсоор боловсруулж гаргасан жишиг, үнэлгээ хийх аргачлал гаргаагүй байна.

Гэвч улс орнууд хар тамхинд донтогчийн ойрын хэрэглээнд хүрэх хэмжээг бага хэмжээнд тооцох тухай НҮБ-ын 1988 оны Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус

³² The role of the quantity in the prosecution of drug offences.ELDD Comparative Study EMCDDA Updated version April 2012.

наймаатай тэмцэх конвенцийн 3 дугаар зүйлд тусгагдсан зарчмыг харгалзан мансууруулах бодисын хэмжээг жингээр нь, тунгийн хэмжээгээр, мөнгөн үнэлгээгээр гаргаж шүүн таслах ажиллагаандаа хэрэглэсээр ирсэн. Ерөнхийдөө Европын 16 улсын эрүүгийн хууль тогтоомжид бага (insignificant), бага бус (substantial), их (large), онц их (notable or especially large, very considerable quantity) гэсэн хэмжээнүүдийг хэрэглэж энэ хэмжээг эрүүгийн хуульдаа шууд заах, тусгай зохицуулсан хууль гаргах, засгийн газрын тогтоол болон сайдын тушаалаар тогтоох, дээд шүүхийн тайлбар гаргах, шүүхийн прецедент тогтоох замаар тодорхойлж иржээ.

САНАЛ 4. Иймд мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын хэмжээг өөрийн улсын нийгэм эдийн засгийн хөгжил, үндэсний болон зан заншлын онцлог, үндэсний аюулгүй байдлын талаарх төрийн бодлого, монгол хүний бие физиологийн шинжид тулгуурлан Эрүүгийн хуульд их, онц их хэмжээг шинжлэх ухааны үндэстэй тогтоох эсхүл Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд нэг мөр тодорхойлж өгөх шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ 5. Эрүүгийн хуулийн 192 дугаар зүйлийн 192.1 дэх хэсэгт “Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг борлуулах зорилгогүйгээр хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан үйлдлийг “давтан” үйлдсэн тохиолдолд хэргийг хүндрүүлэн зүйлчлэх заалт Эрүүгийн хуульд байхгүй байгааг анхаарах, өөрөөр хэлбэл хууль тогтоогч зөвхөн Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг борлуулах зорилгоор хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, борлуулсан үйлдлийг “давтан” үйлдсэн бол хэргийг хүндрүүлэн зүйлчлэхээр заажээ.

САНАЛ 5. Тиймээс мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг борлуулах зорилгогүйгээр хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан үйлдлийг ч мөн адил давтан үйлдэж байгаа хүнд ял хүндрүүлэх үйлчлэх учиртай.

ДҮГНЭЛТ 6. Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэсэн, олж авсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн, борлуулсан үйлдлүүд нь бусдад борлуулах зорилго агуулсан тохиолдолд хэргийг Эрүүгийн хуулийн 192.2-т зааснаар зүйлчлэхээр хууль тогтоогч заасан байна.

Гэвч Эрүүгийн хуулийн 192.2-т заасан диспозиц шинжид дүн шинжилгээ хийж үзвэл “Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг борлуулах зорилго агуулаагүй боловч хууль бусаар “тээвэрлэсэн, илгээсэн” үйлдэлд эрүүгийн хариуцлагад татах боломжтой эсэх нь ойлгомжгүй, өөрөөр хэлбэл “борлуулах зорилго” нь зөвхөн “тээвэрлэсэн, илгээсэн” үйлдэлд хамаарах эсэх талаар хуульч нар маргаж болохоор байна. Хууль сахиулагч борлуулах зорилготой байсан эсэхийг нотлох баримтаар хангалттай нотолж чадахгүй бол энэ зүйлээр зүйлчлэх боломжгүй юм.

САНАЛ 6. Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар “тээвэрлэсэн, илгээсэн” үйлдэл нь энэ төрлийн гэмт хэргийн нийгмийн хор аюулыг нэмэгдүүлэх, мансууруулах бодис хяналтгүйгээр тархах, хэрэглээг нэмэгдүүлэх гол нөхцөл болох тул энэ талаар анхаарч, хуульд өөрчлөлт оруулах эсхүл Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд зохицуулалт хийх нь зүйтэй. Харин хэн нэгэн этгээд өөрөө хэрэглэх зорилгоор мансууруулах үйлчилгээтэй бодисыг хууль бусаар бага хэмжээгээр тээвэрлэж, хадгалж авч явсан бол хэргийг хэрхэн зүйлчлэх талаар практикт маргаан гарч болохыг анхаарах хэрэгтэй.

ДҮГНЭЛТ 7. Эрүүгийн хуулийн 188, 192 дугаар зүйлийн заалтуудаас харахад хар тамхи, мансууруулах бодисыг “хэрэглэх” нь гэмт хэрэг мөн эсэх талаар эрүүгийн хуульд тодорхой заалт байхгүй.

Тухайн этгээд мансуурах болон сэтгэцэд нөлөөт бодисыг түгээх, борлуулах эсхүл өөртөө хэрэглэх зорилгоор олж авсан, тарьсан, хадгалсныг тогтоох өөрөөр хэлбэл хэргийн

сэдэлтийг тодорхойлох нь тэр бүр хялбар бус байдаг бөгөөд илэрсэн бодисын хэмжээгээр энэ асуудлыг шийдвэрлэх нэг боломжийг гадаад улс орнууд практикт өргөн хэрэглэх болсон байна. Тухайлбал өөрийн ойр зуурын хэрэгцээнд хэрэглэх хэмжээний зарим хоруу чанар багатай мансууруулах бодис, бэлдмэлийг хадгалсан, авч явсан, олж авсан, тээвэрлэсэн үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй байх, харин үүнээс хэтэрсэн хэмжээгээр илэрсэн бол бусдад түгээх, борлуулах зорилготой байсан гэж үзэж эрүүгийн хариуцлага хүлээлгэж улмаар тухайн бодисын хэмжээнээс хамааруулан хэргийн хор уршгийг тогтоож хүндрүүлэн зүйлчлэх хандлага түгээмэл болсон байна. Энэ нь мансууруулах бодисын хамааралтай болсон этгээд нь гэмт хэрэгтэн гэхээсээ илүү эмчлүүлэх шаардлагатай өвчтөн бөгөөд нийгэмд учруулах хор аюул нь төдий л их биш, харин мансууруулах бодисын хууль бус тархалттай тэмцэх асуудал мэдээж юуны өмнө түүний тархалтыг хязгаарлах, зогсооход чиглэгдэх ёстой гэж баруунд үздэгтэй холбоотой юм.

САНАЛ 7. Хар тамхи, мансууруулах бодист донтох нь хэрэглэгчийн хувьд эрүүл мэндээрээ хохирох, нөгөө талаар нийгмийн хор аюул ихтэй.

Иймд энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, мансуурах донтой этгээдэд цаг алдалгүй эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх үүднээс энэ хэргийг үйлдэгч нь гэмт хэргээ сайн дураараа илчилж ирсэн, өөрт байгаа мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хуулийн байгууллагад хураалгаж, гэмт хэрэг болон гэмт хэрэг үйлдсэн бусад этгээдийг илрүүлэхэд идэвхтэй дэмжлэг үзүүлсэн бол түүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх заалтыг Эрүүгийн хуульд нэмж оруулах, эсхүл Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд тусгах саналтай байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН